

## СЭДЭВ: УУЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ КРІ-ТАЙ УЯЛДУУЛАХ АРГАЧЛАЛ

### АГУУЛГА

### ОРШИЛ

#### БҮЛЭГ 1. УУЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?, КРІ-ТАЙ УЯЛДУУЛАХ АРГАЧЛАЛ

- 1.1. Стратеги төлөвлөлт, бүрэлдэхүүн хэсгүүд
- 1.2. Уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөө түүний онцлог
- 1.3. КРІ-н гэж юу вэ?, түүнийг стратеги төлөвлөгөөтэй уялдуулах арга

#### БҮЛЭГ 2. УУЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛЖ КРІ-ТАЙ УЯЛДУУЛАХ НЬ

- 2.1. Уул уурхайн компанийн стратегийг тодорхойлох нь
  - 2.1.1. ХХК-н товч танилцуулга
  - 2.1.2. ХХК-н стратеги төлөвлөлт
- 2.2. Стратегид тулгуурлан КРІ-г тодорхойлох нь
- 2.3. Стратеги төлөвлөгөөг КРІ-тай уялдуулах арга

### ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### ХАВСРАЛТ

## Оршил

Сүүлийн жилүүдэд манай улсад уул уурхайн салбар эрчимтэй өсөж байгаа бөгөөд өдөр ирэх тусам шинэ шинэ орд газрууд шинээр нээгдэж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд өсөн нэмэгдсээр байна. Мөн хэд хэдэн томоохон стратегийн ордууд нээгдэж үйл ажиллагаа нь эхлээд явж байна. Иймээс манай улсын хөгжлийн гарц уул уурхайн салбартай нягт холбоотой болж байна. Стратегийн орд газруудаас гадна маш олон орд газруудад үйл ажиллагаа явуулж буй компаниуд байна. Эдгээр компаниудын дийлэнх нь стратеги төлөвлөгөө гаргадаггүй өдөр хоногийг аргацаах байдалтай байдаг бол стратеги төлөвлөгөө гаргадаг цөөн хэд нь стратеги төлөвлөгөөгөө тодорхойлоод орхихоос цаашгүй байгаа. Иймээс уул уурхайн компанийн онцлог талд тулгуурласан стратеги төлөвлөгөө боловсруулах мөн түүнийхээ хэрэгжилтийг хянах, үнэлэх асуудал нэн чухал болоод байна. Уул уурхайн байгууллага нь маш онцлогтой бөгөөд түүнд тохирсон стратеги төлөвлөлтийг боловсруулж түүний хэрэгжилтийн үр дүнг үнэлж, хянаж шалгах арга аргачилалыг бодит жишээн дээр туршиж үзэж цаашид хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох хэрэгтэй. Уул уурхайн салбарын ерөнхий хөгжлийн стратегид тулгуурлан уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөөний онцлогыг гаргаж өгсөн.

Дипломын ажлын зорилго. Уул уурхайн бизнесийн онцлогийг тодорхойлж түүнд нийцтэй стратеги төлөвлөгөөг боловсруулж түүний гүйцэтгэлийг сайжруулах арга замуудыг бодит жишээн дээр судлах, турших

Дипломын ажлын зорилтууд.


1. Уул уурхайн байгууллагын онцлогийг тодорхойлох
2. Уул уурхайн байгууллагын онцлогт тохирсон стратегиуд тодорхойлж гаргах
3. Стратегийг компанийн онцлогтой уялдуулж КPI тодорхойлох

Нэг. Уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөө түүний хэрэгжилтийг сайжруулах арга зам

### 1.1. Стратеги төлөвлөлт, бүрэлдэхүүн хэсгүүд

Байгууллага бизнесийн тоглоомд ялахын тулд менежер юу хийх, юуг улам сайн гүйцэтгэх ёстой вэ гэсэн асуулт байнга гардаг. Үүний хариулт үндсэндээ нэгэн утгатай. Стратегийн сайн боловсруулалт, оновчтой төлөвлөлт тэдгээрийн сайн гүйцэтгэл гэж хэлж болно. Энгийн үгээр хэлбэл төлөвлөлт нь байгууллагын зорилгыг тодорхойлон түүнд хэрхэн хүрэх арга замыг олох цогцолбор ажиллагаа юм. Цаг хугацаа хийгээд хязгаарлагдмал нөхцөлд орон зайг сонгох, сонгосон орон зайдаа хүрэх тусгай чиг баримтлалыг төлөвлөлтийн явцад боловсруулна. Төлөвлөгөөний тусламжтайгаар менежер тулгамдсан асуудалд үнэлгээ өгч, хэрхэн шийдэх арга замаа тодруулж, учирсан бэрхшээл саадыг амжилттай даван туулах бололцоо бүрдүүлнэ.

Төлөвлөлтийг олон янзын аргаар хийж болох боловч стратегийн, дунд хугацааны, үйлдлийн гэсэн шатлалтайгаар хийх нь илүү зохимжтой юм.



Схем 1. Төлөвлөлтийн шатлал<sup>1</sup>

Стратеги нь байгууллагын эрхэм зорилго ба зорилтуудад хүрэхийн тулд зориулагдсан иж бүрэн нарийвчилсан төлөвлөгөө юм. Стратегийн ихэнхи хэсгийг дээд


<sup>1</sup> Байгууллагын менежмент 214-р тал

удирдлага боловсруулдаг боловч түүний хэрэгжилтэнд удирдлагын бүх шатны менежерүүд оролцох эрхтэй байдаг. Стратеги төлөвлөлт нь шаардлага гарсан үед дахин өөрчлөлт хийж болохоор боловсруулагдсан байх ёстой. Байгууллага чухам хаашаа зүглэж, юу хийх гэж байгааг харуулах газрын зургыг стратеги төлөвлөлт гэж энгийнээр томъёолж болно. Менежментийн ухаанд “Стратегийн төлөвлөлт” гэсэн ойлголтыг өнгөрсөн зууны жар, далаад оны заагаас эрчимтэйгээр хэрэглэх болжээ. Байгууллага ямар үйл ажиллагаа явуулахаа урьдаас мэдэж хэрхэн урт удаан оршин тогтнох нь стратегийн менежментээс багагүй шалтгаална. Зах зээлийн орчинд стратегигүй байгууллага баримтлах бодлогогүй, удирдамж болгох зураглалгүй, үр дүнг бүтээх үйл ажиллагааны нэгдмэл төлөвлөгөөгүй гэсэн үг.

Байгууллагын стратегийн менежмент дотоод нарийн уялдаа бүхий таван зорилтот ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын бизнесийн үзэл баримтлалыг боловсруулж, тухайн байгууллага хаашаа чиглэн хөдлөхийг илэрхийлсэн алсын харааг тодорхойлно. Үүний үрээр байгууллага юунд зорьсоноо мэдэрч урт хугацааны чиглэл эрхэм зорилгоо тодорхойлох боломж бүрдэнэ.
2. Эрхэм зорилгыг тусгай тусгай гүйцэтгэлийн зорилтуудад хөрвүүлнэ.
3. Гүйцэтгэлийн зорилтуудаас хамгийн гол нэн чухал болох стратегийг тодорхойлно. Тодорхойлсон стратегээс тусгай аргуудыг ашиглах сонгож хэрэгжүүлбэл зохих стратегийг онохыг эрмэлзэнэ. Энэ бүх нарийн нийлмэл ажиллагааг стратегийн боловсруулалт гэж нэрлэнэ.
4. Сонгосон стратегийг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлнэ. Стратегийн хэрэгжүүлэлт дунд богино хугацааны төлөвлөгөө, төсөв зохиох, бодлого, журам, дүрэм гаргахаас эхэлнэ.
5. Гүйцэтгэлийг үнэлэх, нөхцөл байдлыг хянах, эрхэм зорилго, зорилтууд, стратегид залруулга, өөрчлөлт хийх, чухал ололт туршлага, өөрчлөлт, шинэ санаа, шинэ боломжийг илрүүлнэ.

Эдгээр таван үйл ажиллагаа түүнд хамаарах бүтэц, үйл ажиллагаа, мэдлэгийн салбарыг стратегийн менежмент гэдэг.



Схем 2. Стратегийн менежментийн ерөнхий загвар<sup>2</sup>

Бизнесийн гадаад, дотоод орчинг тогтмол үнэлэн шинжилж түүнд үндэслэн төлөвлөх, бодлого боловсруулахгүйгээр бизнест амжилт гаргах магадлал бага байдаг. Стратегийн менежмент байгууллагын хүний нөөцөд тулгуурлан үйл ажиллагаандаа хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг баримжаалан орчинд дасан зохицох өөрчлөлтийг шуурхай хийж, тависан зорилгодоо хүрэх улмаар урт хугацаанд оршин тогтнох боломжийг бүрдүүлдэг.

### 1.1.1. Стратегийн төлөвлөгөө боловсруулалт

Петер Дракер стратегийн төлөвлөлтийн ажиллагааг таваг гол асуудалд нэгтгэн дүгнэсэн байна. Үүнд:

1. Манай бизнесийн эрхэм зорилго юу вэ?
2. Манай хэрэглэгч хэн бэ?

<sup>2</sup> Ч.Пүрэвдорж, “Байгууллагын менежмент” хуудас 216,

3. Хэрэглэгчдээ үнэлэгдэхийн тулд юу хийх вэ?
4. Манай үр дүн юу байх вэ?
5. Манай төлөвлөгөө юу вэ?

Дээрх таван асуултанд бүрэн хариулт өгсөний дараа стратеги төлөвлөгөөг боловруулах хэрэгтэй. Стратегийн төлөвлөгөөг боловсруулахдаа гадаад, дотоод орчний шинжилгээг хийсний дараагаар боловсруулдаг. Энэ боловсруулах үйл ажиллагаа нь хоёр хэсгээс бүрддэг бөгөөд эхний хэсэгт нь алсын хараа ( Vision ), эрхэм зорилго (Mission), зрхилго ( Goals ), зорилтууд ( Objectives ) зэрэг юу хийх гэж бодсон зоригдохууныг ( Purpose ) тодорхойлох, дараагийнх нь юу хийх гэж санасан тэрхүү зоригдохууныг хэнээр, хэрхэн, хаана, хэзээ хийлгэхийг илэрхийлнэ.

Стратегийн төлөвлөгөө байгууллагын гол зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа түүнд харгалзах нөөцийг санал болгосон үндсэн төлөвлөгөө юм. Стратегийн гурван түвшийн байдаг. Үүнд:


1. Корпорацийн стратеги
2. Бизнесийн стратеги
3. Функцийн стратеги

Корпорацийн стратеги: Энэ түвшинд стратегийн төлөвлөгөөгөөр байгууллагын сонирхож байгаа бизнес тэдгээрийг зарчмын хувьд хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлно.

Бизнесийн стратеги: Байгууллага тодорхой бизнесийг хэрхэн хийх стратегийн төлөвлөгөө юм. Бизнес бүр бизнесийг стратегийн нэгж болно. Ихэнх байгууллагууд бизнесийн стратегийн дагнасан нэгжтэй байдаг.

Функцын стратеги: Корпорацын болон бизнесийн стратегийг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэхэд байгууллага нөөцөө хэрхэн ашиглах асуудалд хамаарах стратегийн төлөвлөгөөг хэлдэг. Зах зээл, санхүү, үйлдэл, хүний нөөц, мэдээллийн менежмент, судалгаа ба хөгжил менежмент зэрэг функцын стратегийн үндсэн хэсгүүд юм. Стратеги төлөвлөлтийг ерөнхий бүдүүвчээр харуулбал дараах хэлбэртэй байна.

Схем 3. Стратеги төлөвлөлтийн ерөнхий бүдүүвч<sup>3</sup>



Стратегийн төлөвлөлтийг хийхэд орчны болон нөхцөл байдацлын шинжилгээ зайлшгүй хэрэгтэй байдаг.

### 1.1.2. Байгууллагын орчны шинжилгээ

#### Гадаад орчны шинжилгээ

Байгууллагын гадаад орчинд макро болон микро орчин багтдаг

**Макро орчин:** Энд байгууллагын үйл ажиллагаанд шууд бус байдлаар нөлөөлдөг хүчин зүйлс болох эдийн засаг, хүн ам зүй, технологи, нийгэм соёл, улс төр хууль эрх зүйн зэрэг хүчин зүйлс багтана. Эдгээр хүчин зүйлсийн өөрчлөлт нь байгууллагад дам болон дам бусаар нөлөөлдөг байна.

<sup>3</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 15, УБ 2011

- Эдийн засгийн хүчин зүйлс: Байгууллагын үйл ажиллагаанд инфляц, ажилгүйдэл, зээлийн хүү, нийт эрэлт зэрэг хүчин зүйлсүүд нөлөөлөл үзүүлдэг. Мөнгөний ханшийн уналт нь байгууллагад нөөцүүдийг худалдан авахад хүндрэл учруулж өртгийг их хэмжээгээр нэмэгдүүлдэг. Зээлийн хүү нь хөрөнгө оруулалтыг багасгаж ажилгүйдлийг нэмэгдүүлэн худалдан авах чадварыг бууруулдаг байна. Эдийн засгийн орчны шинжилгээ хийхэд ажил эрхлэлт, үндэсний цэвэр бүтээгдэхүүн, хүн амын мөнгөн орлого, хадгаламж зээлийн хүү, бүтээмж, мөнгөний нийлүүлэлт, хэрэглээний барааны үнийн индекс, түүхий эд материалын нөөц зэрэг гол гол үзүүлэлтүүдийг ашигладаг.
- Хүн ам зүйн хүчин зүйлс: Хүн ам зүйн хүчин зүйл нь байгууллагын хөгжилд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд нийгмийн гишүүдийн нас хүйс, гэр бүлийн байдал, амьдарлын хэв маяг, боловсрол, орлого, ажил мэргэжлийн байдал зэргээр тодорхойлогддог. Мөн хүн зүйн орчныг судлахад төрөлт, нас баралт, гэрлэлт зэрэг нь чухал шаардлагатай хэмжигдэхүүн болдог.
- Технологийн хүчин зүйлс: Байгууллага нь нөөцийг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хувиргах үйл явцыг технологи тодорхойлж өгдөг. Технологи нь нэг талаас байгууллагын гадаад орчинг тодорхойлогч хүчин зүйл бөгөөд улс орны хөгжлийг технологийн дэвшилээр мөн тодорхойлдог. Өнөөдөр дэлхий дахинд эрчим хүч, материал, тээвэр, мэдээлэл холбоо, удамшил зэрэг хүрээг хамарсан технологийн 5 ангилалыг ашиглаж байна.
- Нийгэм соёлийн хүчин зүйлс: нийгэм дэх хүн амын зан заншил, үнэт зүйлс, дадал зуршил, анги давхарга, ёс зүй зэргийг нийгэм соёлын хүчин зүйлст багтаан ойлгоно. Байгууллага нь тодорхой соёлын орчинд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тухайн соёлын орчинг судлан үйл ажиллагаагаа түүнд зохицуулан явуулах нь зүйтэй.
- Улс төр, эрх зүйн хүчин зүйлс: Тухайн улс орны бизнесийн талаар явуулж буй төрийн бодлого, хууль тогтоомж, мөн бизнес эрхлэх эрх зүйн таатай орчин зэрэг нь бизнесийн байгууллагуудыг зах зээлд амжилттай ажиллах боломжийг нэмэгдүүлж улмаар эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой юм. Өнөөгийн глобалчлалын эрин зуунд дэлхийн нийтийн чиг хандлагатай хөл нийлүүлэн олон улсын зах зээлд гарч амжилттай ажиллахын тулд тухайн улс орнуудын эрх зүйн орчин, хууль тогтоомжуудыг сайбар судлан ажиллах шаардлагатай.

Байгууллага нь гадаад орчны үйлчлэлд зохицон ажиллахын тулд дараах үндсэн нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- Гадаад орчны хүчин зүйлүүдийн уялдаа холбоо буюу хүчин зүйлүүдийн өөрчлөлтийн улмаас нэг нь нөгөөдөө үзүүлэх нөлөөллийн хэмжээ
- Гадаад орчны хувьсамтгай хөдөлгөөнт чанар буюу гадаад орчны өөрчлөлтийн хурд
- Гадаад орчны нарийн нийлмэл байдал буюу байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн тоо
- Гадаад орчны тодорхойгүй байдал буюу гадаад орчноос хүлээн авч буй мэдээллүүдийн үнэн зөв байдал зэрэг болно.


Микро орчин. Байгууллагын микро орчинд нийлүүлэгч, хэрэглэгч, өрсөлдөгч, нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, иргэд орж байдаг бөгөөд эдгээр нь байгууллагын үйл ажиллагаанд шууд нөлөөлж байдаг учир өрсөлдөөний хүчин зүйлс нь микро орчны хүчин зүйлстэй салшгүй холбоотой. Иймээс менежер энэхүү орчинг судлах нь зайлшгүй



байдаг. М.Портер өрсөлдөөний хүчин зүйлсийг үнэлэх “Өрсөлдөөний 5 хүчний загвар”-г боловсруулсан. Үүнд:

Өрсөлдөөний хүчин зүйлст: Шинэ өрсөлдөгч нэвтрэх аюул / threat of entry /, Орлуулах бүтээгдэхүүний аюул / threat of substitute /, худалдан авагчийн нөлөөлөх чадвар / bargaining power of buyers /, нийлүүлэгчдийн нөлөөлөх чадвар / bargaining power of suppliers /, өрсөлдөөний төлөв байдал / competitive rivalry /, зэрэг ордог.

Схем 4. М.Портер Өрсөлдөөний 5 хүчний загвар<sup>4</sup>



<sup>4</sup> Ж.Бат-Оргил, “Өрсөлдөөний стратеги” хуудас 78, УБ 2009

### Шинэ өрсөлдөгчид нэвтрэх аюул:

Шинэ өрсөлдөгчид нэвтрэх аюул нь тухайн салбарт шинэ байгууллага ороход хэр хялбар байгааг харуулсан ойлголт юм. Салбарт нэвтрэхэд хялбар байх тусам байгууллагууд шинээр нэвтэрсээр байх бөгөөд энэ нь эцэстээ салбарын нэг байгууллагад ногдох ашгийн хэмжээг бууруулдаг. Аливаа салбарт шинээр нэвтрэх боломж нь тухайн салбарт нэвтрэх боломжийг хязгаарласан саадын төвшингөөс хамаардаг. Тиймээс үйл ажиллагаа нь жигдэрчихсэн байгууллагуудын хувьд саад хэр их байна төдий чинээ шинээр өрсөлдөгч байгууллагууд орж ирэх аюул бага байна. Саад гэж салбарт шинээр орж ирэх байгууллагууд амжилттай үйл ажиллагаа явуулахын тулд зайлшгүй биелүүлэх шаардлага гэж ойлгож болно. Дараах төрлийн саадууд байдаг.

- Эдийн засгийн үр ашиг. Ямар ч байгууллагын хувьд бүтэгдэхүүний борлуулалт нэмэгдэх тусам нэгж бүтээгдэхүүнд ногдох зардал буурдаг. Тиймээс тухайн салбарт томоохон байгууллагууд өргөн далайцтай үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд зах зээлд шинээр нэвтрэх нь нэлээд эрсдэлтэй алхам байх болно. Мөн энд туршлагын туруйн асуудал ч хамааралтай.
- Бүтээгдэхүүний ялгарал. Бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал хэдий чинээ их байна төдий чинээ худалдан авагчдын тодорхой бүтээгдэхүүний талаарх итгэл үнэмшил их байх бөгөөд тэр нь зах зээлд шинээр орж ирэгсдэд төвөгтэй байдлыг бий болгодог.
- Түгээлтийн сувагт нэвтрэх боломж. Хэвтээ интеграци ихтэй салбарт нэвтрэх боломж маш бага байдаг.
- Хууль зүйн зохицуулалт. Зарим салбарт төрөөс хуулиар өндөр хязгаарлалт тогтоосон байдаг.
- Эхлэх болон хөрөнгө оруулалтын өндөр зардал. Үйл ажиллагаа явуулж эхлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг салбарт нэвтрэх боломж санхүүгийн чадавхи муутай, жижиг байгууллагуудын хувьд хүндрэлтэй юм.
- Үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас үзүүлэх дарамт. Зэх зээлд нэвтрэхээр сонирхож буй байгууллага үйл ажиллагаа явуулаад эхэлчихсэн байгууллагуудын зүгээс янз бүрийн дарамт шахалт үзүүлнэ гэж үзвэл нэвтрэх саад ихтэй гэж үзэж болно.

### Орлуулах бүтээгдэхүүний аюул

Орлуулах бүтээгдэхүүн гэдэг нь тухайн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээтэй адил хэрэгцээг хангахад чиглэгдсэн байдаг боловч ялгарахуйц өөр процессын дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ юм. Байгууллагууд ихэвчлэн өөрсдийн шууд өрсөлдөгчдөл анхаарлаа хандуулаад орлуулах бүтээгдэхүүний аюулыг мартаж хандлага ажиглагддаг. Тиймээс байгууллага нь шууд өрсөлдөгчдөөс гадна орлуулах бүтээгдэхүүний үнэ, үйлдвэрлэлийн зардал болон өсөлт зэрэгт анхаарлаа хандуулж байх шаардлагатай юм. Дараах тохиолдлуудад орлуулах бүтээгдэхүүний аюул нэмэгдэж байдаг.

- Оруулах бүтээгдэхүүний зардал буурах.
- Орлуулах бүтээгдэхүүний шинэ санаа , шинэлэг бүтээл нэвтэрч эрэлтийг тухайн салбарт хандуулах.
- Орлуулах бүтээгдэхүүний зах зээлд өрсөдөөн нэмэгдэж үнэ буурах зар сурталчилгаа идэвхжих.

Энэ хэсэгт хамгийн гол ойлгох ёстой нэг зүйл бол орлох бүтээгдэхүүний үнэ болоод хэрэглэгчдийн хэрэгцээг хангах чадварын асуудал гэдгийг хэлэх нь зүйтэй.

### Худалдан авагчдын нөлөөлөх чадвар

Худалдан авагчид нь байгууллага оршин тогтнолын үндэс байдаг бөгөөд зарим салбарт худалдан авагчид үйлдвэрлэгчид үзүүлэх нөлөөлөл маш өндөр оршин тогтнох эсэхийг шийдвэрлэх тохиолдол ч гардаг.

- Худалдан авагчдын төвлөрөл их байх. Худалдан авагчийн үйлдвэрлэгчий тоо цөөн блэх хувь өндөр байх үед нөлөөлөх чадвар нь өндөр байдаг. Тиймээс худалдан авагчдын тоо цөөн байх тусам нөлөөлөх чадвар өндөр байх бөгөөд энэ үед тэд бүтээгдэхүүн үйлчилгээг аль болох бага үнээр авах чармайлт гаргаж үйлдвэрлэгчдийн ашгийг шахдаг
- Өөр нийлүүлэгчдэд хандах зардал бага байх. Энэ нөхцөл нь ялгарал бага бүтээгдэхүүний зах зээлд илүү ажиглагддаг. Тухайлбал нүүрс
- Орлуулах бүтээгдэхүүн их байх
- Худалдан авагчид өөрсдөө тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг эрэлхийлэх

Худалдан авагчийн нөлөөлөх чадвартай холбогдуулан нэг асуудалд тайлбар хийх шаардлагатай юм. Худалдан авагчийг эцсийн хэрэглэгчээс ялган авч үзэх шаардлагатай. Эцсийн хэрэглэгчийн нөлөөлөх чадвар өндөр байх нь ховор байдаг. Гэхдээ жижиг байгууллагын хувьд энэ байдал элбэг тохиолддог.

#### Нийлүүлэгчдийн нөлөөлөх чадвар

Аливаа байгууллагын бүтээгдэхүүн , үйлчилгээг бий болгоход орох түүхий эдийг нийлүүлдэг байгууллагыг нийлүүлэгч гэдэг.

Дараах хүчин зүйлс нийлүүлэгчийн худалдан авагчид нөлөөлөх чадварыг нэмэгдүүлдэг байна.

- нийлүүлэгчдийн төвлөрөл.Цөөн тооны нийлүүлэгч байх нь мэдээж худалдан авагчдын сонголтыг багасгах бөгөөд энэ нь нийлүүлэгчдийн нөлөөлөх чадавхийг нэмэгдүүлдэг.
- Орлуулах бүтээгдэхүүн бага байх. Нэгэнт орлуулах бүтээгдэхүүн бага байгаа бол худалдан авагчийн сонголт хийх боломж буурна.
- Нийлүүлэгчид өөрсдөө бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахаар төлөвлөж байгаа.
- Бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал их
- Өөр нийлүүлэгчтэй хамтран ажиллах эхлэхэд гарах зардал өндөр гэх мэт.

#### Өрсөлдөөний төлөв байдал

Өмнө дурдсан дөрөв болон бусад хүчин зүйлсийн нөлөөлөл үйлчлэлээс хамаараад салбар дахь өрсөлдөөний төлөв байдал янз бүр байж болно.

Дараах хүчин зүйлс өрсөлдөөний төлөв байдлыг хурцатгахад голлох үүрэг гүйцэтгэдэг байна.

- Зах зээлийн өсөлтийн хурдац. Зах зээлийн өсөлт өндөр байх тохиолдолд байгууллагуудын үйл ажиллагаа зах зээлтэйгээ зэрэгцэн өсөж байдаг бол өсөлт удааширснаар байгууллагууд нэг нэгнээсээ хувь булаацалдаж эхэлдэг. Энэ байдал манай архи пивоны зах зээл дээр нэлээд тодорхой ажиглагдаж байгаа.

- Өрсөлдөгчдийн тэнцвэрт харьцаа. Ижил хэмжээ хүхий олон өрсөлдөгчтэй зах зээл дээр өрсөлдөөн хурц ширүүн байдаг. Харин эсрэгээр ганц хоёр давамгайлах болон жижиг байгууллагуудаас бүрдэх зах зээл дээр өрсөлдөөний төлөв байдал харьцангуй тайван байдаг.
- Өндөр тогтмол зардал. Тогтмол зардал өндөртэй салбар нь харьцангуй өрсөлдөөн ихтэй байх нь элбэг байдаг. Ийм салбарт үйл ажиллагаа яввуулж буй байгууллага зардлаа бууруулахын тулд өргөн цар хүрээнд үйлдвэрлэл явуулдаг бөгөөд үүний үр дүнд үнээ ч буулгах боломжтой болдог. Энэ нь өрсөлдөгчдийг энэ байдлаар тэмцэхэд хүргэдэг бөгөөд эцэстээ ялагчгүй үнийн дайн болж хувирдаг байна.
- Салбараас гарах зардал өндөр байна. Энэ тохиолдолд байгууллагууд зах зээл дээр оршсоор байх бөгөөд салбарын амьдрал дуусах дөхөх тусам өрсөлдөөн нэмэгддэг байна.
- Ялгарал бага байх. Бүтээгдэхүүн үйлчилгээний ялгагдах чанар бага байх нь өрсөлдөөнийг үнэ дээр төвлөрөхөд хүргэдэг. Түүхий эдийн зах зээл дээр энэ байдал нэлээд ажиглагддаг.

Таван хүчний шинжилгээ хийснээр байгууллага зүгээр л тэдгээр хүчин зүйлсийн талаарх тодорхойлолттой хоцорч болохгүй. Харин тухайн салбарт үйл ажиллагаа явуулах нь хэр оновчтой болох цаашлаад нөхцөл байдлыг хэрхэн өөртөө ашигтайгаар эргүүлж болохыг тогтооход чиглэгдэх ёстой. Байгууллага таван хүчин зүйлсийн нөлөөлөл өндөр байх тохиолдолд зах зээлээс гарах тэдгээрийн хүчийг сулруулах алхам хийж болох бөгөөд харин тэдээгийн үйлчлэл сул үед хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх нь зүйтэй байдаг.

Таван хүчний шинжилгээ гэж нэрлэгддэг энэхүү аргачлалыг ашиглахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй .

зах зээлийн сегмент. Салбарын шинжилгээг зах зээл дээрх сегментүүд нь илт ялгаатай тохиолдолд тухайн салбар дахь сегмент тус бүрээр хийх нь тохиромжтой байдаг. Сегмент тус бүрээр хийсний дараа тэдгээрийг нэгтгэн дүгнэх хэрэгтэй.

Нэгдэж буй салбар. Технологийн дэвшил болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр салбарууд нэгдэх хандлага ажиглагдах болсон.

Салбарын амьдралын мөчлөг. Таван хүчин зүйл тэдгээрийн харилцан үйлчлэл нь тухайн салбарын амьдралын мөчлөгөөс хамаараад харилцан адилгүй байдаг.

### 1.1.3. Эрхэм зорилго, зорилгыг тодорхойлох.

Эрхэм зорилго нь одоо болон ирээдүйн үйл ажиллагааны талаарх хүсэл эрмэлзлэл, үнэ цэнэ, итгэл үнэмшил, тухайн байгууллагын өрсөлдөгчөөс ялгарах ялгаа зэргийг илэрхийлсэн гол зорилго юм. Байгууллагын эрхэм зорилго нь тухайн байгууллагын бизнесийн тодорхойлолт, философи, итгэл, ирээдүйн хөгжлийн үзэл баримтлалыг хамгийн товчоор өөртөө багтаасан байх ёстой. Эрхэм зорилго нь байгууллагын оршин тогтнох гол нөхцөл нь болдог бөгөөд бусад зорилгын иж бүрдэл нь байдаг. Эрхэм зорилгын мөн чанар агуулгыг тодорхойлохдоо доорх зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Хэт өргөн хүрээтэй эсвэл явцуу байхаас зайлс хийх
- Хүлээн авагчийн анхаарлыг татхуйц байх
- Бизнесийн мөн чанарыг тод томруун тусгасан байх
- Анхаарал татхуйц өвөрмөц байх
- Бүтээгдэхүүнээс илүү зах зээлд чиглэсэн байх

#### Эрхэм зорилго боловсруулах

Эрхэм зорилгыг боловсруулахдаа дараах асуултуудад зөвшөөрсөн хариулт өгч байгаа эсэхийг шалгаж үзэх хэрэгтэй. Хэрэв зөвшөөрсөн хариулт өгч чадахгүй байгаа бол эрхэм зорилго боловсруулах асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай.

- Эрхэм зорилгоор дамжуулан бидний хүсч байгаа үр дүн, ашиг нь цаг хугацааны хувьд тохирч байна уу?
- Урт удаан хугацаанд манай амжилтад нөлөөлөх удирдлагын дадлага чадвар, мэргэжлийн түвшин бий юу?
- Үр дүнтэй эрхэм зорилго боловсруулахад зайлшгүй хэрэгтэй хөрөнгө оруулалтыг бид цаг хугацаанд нь хийж чадах уу?

- Хэрэглэгч, өрсөлдөгч болон бусад хүмүүст өөрийн эрхэм зорилгыг ойлгоход туслахыг бид хүсч байна уу?
- Дээд шатны удирдлагууд өөрсдийн ажил хэргийн ур чадвараа дээшлүүлж өөрсдийгөө үлгэр жишээ болгохыг хүсч байна уу?
- Эрхэм зорилгын мэдэгдлийн утга нь цаг хугацаа тавигдаж байгаа шаардлагад нийцэж байна уу?
- Бидний шийдэх гэж байгаа асуудлууд, хэрэглэгч, өрсөлдөгч болон бусад хүмүүст ойлгомжтой, бүрэн дүүрэн биелэгдэхүйц байгаа эсэхэд игэлтэй байна уу?
- Манай эрхэм зорилго ерөнхийдөө байгууллагын үйл ажиллагаанд бүрэн чиглэгдэж чадаж байна уу?

Эрхэм зорилгыг боловсруулахад байгууллагын ажилчид болон менежерүүдийг идэвхитэй оролцуулах нь түүний биелэгдэх боломжийг нэмэгдүүлж байдаг.

### Зорилго

Эрхэм зорилгоос байгууллагын зорилго урган гарах бөгөөд хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг. Зорилго нь байгууллагын эрхэм зорилгын амжилт, хэрэгжилтийг хэмжих чухал хэрэгсэл болж өгдөг. Зорилгыг тодорхойлсоноор дараах ач холбогдолтой.

- Зорилго нь удирдлагын үндэс суурь болдог
- Байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх аргуудыг тодорхойлж өгдөг
- Ажил хэрэгч шийдвэр гаргах үндэс суурь нь болж өгдөг
- Тодорхой төлөвлөгөөний үзүүлэлтүүдийг томъёолох удирдамж болж өгдөг зэрэг болно

Зорилгийг хэрэгжих хугацаанаас нь хамаарч урт, дунд, богино хугацааны гэж ангилдаг. Урт хугацааны зорилго нь байгууллагын эрхэм зорилготой нягт уялдаатай бөгөөд тодорхой тоон үзүүлэлтүүдийг агуулдаггүй. Дунд болон богино хугацааны зорилго нь

тодорхой тоон болон чанарын агуулгыг илэрхийлж байдаг бөгөөд ямар зорилго ямар хугацаанд биелэгдэх ёстойг заасан, хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байдаг.

П.Дракер аливаа байгууллаг нь ганц зорилгод бүх хүчээ төвлөрүүлж болохгүй бөгөөд хамгийн чухал хэд хэдэн чиглэлийн зорилгыг сонгон хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзээд дараах чиглэлүүдийг тодорхойлсон<sup>5</sup>. Үүнд:

- Зах зээлийн төлөв байдал
- Шинэчлэлт
- Ажиллах хүчний болон үйлдвэрлэлийн бүтээмж
- Бодит болон санхүүнийн нөөц
- Ашиг
- Удирдлагын ур чадвар
- Олон нийтийн үүрэг хариуцлага гэх мэт.

Зорилго, зорилтууд нь дараах шалгууруудыг хангасан байх ёстой бөгөөд эдгээр шалгуурууд нь зорилгын чанарыг тодорхойлоход туслана. Үүнд: Хүрэхүйц, хэмжигдэхүйц, Хугацаатай байх гэсэн үндсэн шалгуурууд байдаг.

#### **1.1.4. Стратегийн томъёолол**


Байгууллагын стратегийг томъёолохын тулд тухайн стратеги нь байгууллагын сул тал ба хүчтэй тал, аюул ба боломжтой маш нарийн холбогдож байдаг. Стратегийг томъёолохдоо байгууллагын эрхэм зорилго, зорилго, зорилтуудыг тодорхойлсоны дараа дээд удирдлагууд томъёолдог. Байгууллагын стратеги нь гурван түвшинд оршиж байдаг. Үүнд:

- Нэгдсэн түвшин дэх стратеги
- Бизнесийн нэгж дэх стратеги
- Функционал стратеги

<sup>5</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 54, УБ 2011



Нэгдсэн түвшний стратегийг: томъёолохын тулд тухайн стратеги нь байгууллагын сул ба хүчтэй тал, боломж ба аюултай маш нарийн холбогдож байдаг. Нэгдсэн түвшний стратегийн дараах хэлбэрүүд байдаг. Үүнд:



Схем 5. Стратегийн сонголт<sup>6</sup>

Өсөлтийн стратеги. Энэ стратеги нь дараах нөхцөлд хэрэгжих боломжтой.

- Бизнесийг хөгжүүлэхэд гадаад орчны таатай боломж бүрдсэн ба түүнийг ашиглах шаардлага бий болох
- Өрсөлдөх давуу тал болон зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх боломж бүрдсэн
- Удирдлагын зүгээс байгууллагыг өргөжүүлэх, өсгөх зорилго тавьсан

Энэ стратегийг SWOT шинжилгээний SO тал нь давамгайл байгаа тохиолдолд баримтална. Өсөлтийн стратеги нь дотоод өсөлтийн, нэгдэх, хэвтээ интеграци, босоо интеграци, конгломерат, хамтарсан үйлдвэр зэрэг дэд стратегиудаас бүрдэнэ.

- Дотоод өсөлтийн стратеги. Энэ стратеги нь бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх, ажиллах хүчний өсөлт зэрэг хүчин зүйлсийг авч үздэг. Дотоод өсөлтийн стратегийг хэрэгжүүлсэнээр байгууллага нь өөрийн дүр төрхийг хадгалж, нэр хүндээ өсгөн тогтвортой байдлаа хангадаг.

<sup>6</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 60, УБ 2011

- Нэгдэх стратеги. Зах зээлийн хувь хэмжээг өсгөх нөөцийг үр ашигтай болгох зорилгоор ижил түвшний байгууллагууд энэ стратегийг хэрэгжүүлдэг. Нэгдэх стратегийг баримталж буй үед амжилттай ажиллахын тулд дараах нөхцөлийг анхаарч үзэх хэрэгтэй.
  - Нэгдэж буй байгууллагуудын зорилгын нэгдэл
  - Байгууллага тус бүрийн стратегийн давуу тал, бизнесийн нийцэл
  - Нэгдэлтийн дараах удирдлагын хяналт, оновчтой бүтэц, байгууллагын соёлын зөрүү, боловсон хүчний өөрчлөлт, дасан зохицолт гэх мэт.
- Хэвтээ интеграци. Энэ нь нэг чиглэлийн бизнесээр өөр өөр компанийг бий болгох, эзэмшилдээ авах зэргээр өргөжих үйл ажиллагаа юм.
- Босоо интеграци. Энэ стратеги нь байгууллагын эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бэлтгэн нийлүүлэгчээс хэрэглэгч хүртэлх борлуулалт болон түгээлтийн сувгийг нэмэгдүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа юм.
- Конгломерат. Энэ нь хоорондоо уялдаа хамааралгүй олон төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх явдал бөгөөд төрөлжилтийн стратегийг хэрэгжүүлснээр хүлээх эрсдлийг бууруулна.
- Хамтарсан үйлдвэр. Энэ нь хоёр талаас өөрсдийн стратегийн давуу тал дээр тулгуурлан тодорхой хугацаанд байгуулсан хамтран өсөлтөд хүрэх зорилготой холбоо, нөхөрлөл юм.

Тогтвортой байдлыг хангах стратеги. Энэ стратеги нь байгууллагын ерөнхий үйл ажиллагааны тогтворжилтод гол анхаарлаа хандуулан түүнийг хэюээр нь байлгах буюу бизнесийн багцад онцийн өөрчлөлт оруулахгүй байх явдал юм. Тогтвортой байдлыг хангах стратегийг хоёр стратегийн дунд холбоос байдлаар богино хугацаанд хэрэгжүүлдэг. Энэхүү стратегийг орчны нөлөөлөл бага буюу SWOT шинжилгээний SO тал нь дунд түвшинд байгаа, байгууллагын ерөнхий үйл ажиллагаа зэх зээлийн өсөлт бага эсвэл өсөлтгүй байгаа нөхцөлд баримтална.

Бууралтын стратеги. Энэ стратеги нь хорогдуулах, татан буулгах, задлах арга замаар хэрэгждэг. Мөн олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага өөрийн нөөцийг зохистой ашиглах арга болгон ашигладаг.

- **Хорогдуулах:** Энэ нь санхүүгийн хүндрэлд орсон байгууллага ашиггүй салбар нэгжээсээ салах, худалдах зэргээр хүнд байдлаас гарах арга.
- **Татан буулгах:** Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь зогсоож хөрөнгийг худалдан татан буулгах арга юм.
- **Задлах:** Энэ нь ашиггүй бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс татгалзаж, илүүдэл ажиллах хүчийг халах, муу ажиллаж байгаа хувиарлалтын сувгийг хаах, нөөцийг үр ашигтай ашиглах арга замыг хайх зэрэг арга хэмжээ юм.

Хосолсон стратеги. Өсөлт, тогтворжилт, бууралтын үндсэн стратегиудыг нэгэн зэрэг ялгаатай бизнест эсвэл өөр цаг хугацаанд нэг бизнест хэрэгжүүлэх тохиолдлыг хосолсон стратеги гэнэ. Тухайн багууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний амьдралын мөчлөг өөр өөр үе шатанд байх мөн орчны өөрчлөлт түргэн байх зэрэг нь энэ стратегийг хэрэгжүүлэх нөхцөл болдог.

### 1.1.5. Стратегийн шалгуурууд ба сонголт

Байгууллага нь стратегийн үндсэн хувилбаруудаас хамгийн оновчтойг сонгон авах шийдвэрийг стратегийн сонголт гэнэ. Энэ шийдвэр буюу сонголтыг хийхийн тулд тухайн стратегийн үйл ажиллагааны хувилбаруудыг харьцуулан тэдний гол хүчин зүйлүүдийг үнэлж үзэх шаардлагатай. Стратегийн сонголтыг хийхийн тулд дараах нөхцлүүдийг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:


- Тухайн стратеги нь сайтар судлагдсан эсэх
- Стратегийг сонгосноор хэн юу хийх нь тодорхой болох уу?
- Уг стратеги нь орчны бүх боломжийг бүрэн ашиглаж чадаж байна уу?
- Өрсөлдөх давуу тал, суурь чадамж, нөөцтэй нягт уялдаж чадсан эсэх
- Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлстэй нийцэж байгаа эсэх
- Сонгосон түвшний эрэлтийг тооцсон эсэх зэрэг болно.

Стратеги нь сайн боловсруулагдсан эсэхийг үнэлэх дараах гурван хэмжээс байдаг. Үүнд:

- Сайн стратеги нь байгууллагын нөхцөл байдал болон гадаад дотоод хүчин зүйлсийн боломж хүсэл эрмэлзлэлд маш сайн нийцсэн байх ёстой.
- Сайн стратеги нь өрсөлдөөний давуу талыг дэмждэг. Стратеги нь өрсөлдөөнд илүү хүчирхэг, үр ашигтай байдлыг нь бий болгоход тусалдаг
- Сайн стратеги нь байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлдэг. Гүйцэтгэлийг сайжруулахад хоёр зүйл маш чухал. Ашгийг нэмэгдүүлэх, байгууллагын урт хугацааны бизнесийн давуу тал болон өрсөлдөөний байршил.


Стратегийн сонголтыг хийх объектив болон субъектив гэсэн үндсэн хоёр хандлага байдаг. Объектив хандлагад сонголтын матриц, туршлагын муруй, хугарлын цэгийн шинжилгээ зэрэг шийдвэр гаргалтын бусад тоон болон чанарын аргууд багтана. Субъектив хандлага нь ерөнхийдөө удирдлагын туршлага, мэдрэмж, зөн совин, байгууллагын соёлд тулгуурладаг бөгөөд бүлгийн шийдвэр гаргах аргууд болох Номинал бүлгийн арга, Делфи арга, Ринги, Оюуны довтолгооны зэрэг аргуудыг ашигладаг.

Сонголтын матрицууд



Схем 6. SWOT шинжилгээний диаграмм<sup>7</sup>

Схем 7. BCG матриц<sup>8</sup>



<sup>7</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 75, УБ 2011

<sup>8</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 75, УБ 2011

Од. Энэ талбарт байрлаж буй байгууллага нь өрсөлдөх чадвар, зэх зээлийн боломжийг ашиглах үүднээс өргөжилтийн стратегийг ихэвчлэн баримтална. Байгууллагын бизнес нь урт хугацаанд өсөх, ашиг олох боломж хамгийн сайныг харуулна. Энэ бизнес нь бэлэн мөнгөний эргэлт ихтэй хэдий ч их хэмжээний мөнгө хэрэглэх шаардлагатай.

Мөнгөний үнээ. Энэ талбарт буй бизнес нь бэлэн мөнгөний их хэмжээний эргэлтийг бий болгодог бөнөөд хөрөнгө оруулалт хийх шаардлага багатай байдаг. Зах зээлд эзлэх хувь харьцангуй өндөр боловч өсөлтийн норм нь доогуур. Энэ нь өөрийн давуу байдлаа аль болох урт хугацааны туршид сайжруулан зохицуулахыг хичээх шаардлагатай.

Асуултын тэмдэг. Энэ талбарт буй бизнес нь бэлэн мөнгөний эргэлт бага, их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг. Салбар нэгж энэ байрлалд байрлаж байвал зэх зээлийн хувь хэмжээ бага боловч салбарын борлуулалтын өсөлт ихтэй байдаг. Зах зээлийн өсөлтөө ашиглан түргэн од болох боломжтой.

Нохой. Энэ талбарт буй бизнес нь мөнгөний эргэлт бага ирээдүй байхгүй бизнес юм. Үүнд хамаарах байгууллагын нэгж нь маш бага зах зээлийн харьцангуй хувийн байршилтай мөн салбарын өсөлтийн норм маш удаан бараг өсөлтгүй байдаг. Бизнесийн нэгж нь нохой байрлалтай байх үед бизнесээ худалдах буюу бууралтын стратеги бармтлах нь хамгийн оновчтой хувилбар юм.

Хүснэгт 1. Стратегийн үнэлгээний TOWS матриц<sup>9</sup>

Дотоод хүчин зүйлс Гадаад хүчин зүйлс	<u>Давуу талууд (S)</u> ..... .....	<u>Сул талууд (W)</u> ..... .....
	<u>Боломжууд (O)</u> ..... .....	<u>SO стратеги</u> ..... .....
<u>Аюул (T)</u> ..... .....	<u>ST стратеги</u> ..... .....	<u>WT стратеги</u> ..... .....

<sup>9</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 87, УБ 2011

## Салбарын стратеги

М.Портер салбарын буюу бизнесийн нэгжийн өрсөлдөөний орчинд хэрэглэж болох ерөнхий гурван стратегийг боловсруулсан. Үүнд:

Өртгөөр давамгайлах стратеги. Энэ стратеги нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлаа өрсөлдөгчийнхөөсөө боогуур байлгаж давуу тал олж авах явдал юм. Өртгөөр давамгайлах стратеги нь зах зээлийн тодорхой нэг хэсэг буюу газар зүйн бүс нутгаар хуваасан багахан нэгж хэсэгт бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг чармайдаг.

Ялгарах стратеги. Энэ стратеги нь бага зардлын стратегитай адил зах зээлийн тодорхой нэг хэсэг буюу газар зүйн бүс нутгаар хуваасан багахан нэгж хэсэгт бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг чармайдаг бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний өвөрмөц бодлогоор дамжуулан зах зээлийн хэд хэдэн сегментийг шууд эзэмших зорилготой үйл ажиллагаа юм. Байгууллага нь ялгагдах онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг зэх зээлд санал болгон зах зээл тус бүрт өрсөлдөгчөөс илүү байр суурь эзэлж авахад анхаардаг.

Төвлөрөх стратеги. Энэ стратеги нь зах зээлийн нэг эсвэл хэд хэдэн багахан сегментэд төвлөрөн хувь хэмжээгээ нэмэгдүүлэх үйл ажиллагаа юм. Төвлөрөх стратегийг хязгаарлагдмал нөөц бүхий жижиг байгууллагууд хэрэгжүүлэхэд тохиромжтой.


Дээрх гурван стратегиас гадна бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн системийн зохион байгуулалттай холбоотой стратегиуд байдаг. Үүнд:

- Процесс төвлөрсөн стратеги
- Бүтээгдэхүүнд төвлөрсөн стратеги
- Завсрын стратеги


## Бизнесийн нэгжийн стратеги

Байгууллагын бизнесийн нэгж бүр нь өөр зах зээл өөр өрсөлдөгчтэй байдаг бөгөөд ялгаатай стратегийг баримтлах хэдий ч байгууллагын ерөнхий зорилго, нэгдсэн түвшний стратегийг бизнесийн нэгжийн стратеги нь бүрддэг.

- Niche- бага зардлын стратеги: Энэ стратеги нь зах зээлийн жижиг сегментэд бага зардлаар ажиллахыг онцолдог. Бизнесийн нэгжүүд нь үнийн мэдрэмжтэй, цөөн хэрэглэгчдэд буюу niche-д /Зах зээлийн өчүүхэн бага хэсэг/ зориулан энгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлдэг байна. Тухайн энгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь бусад өрсөлдөх бизнесээс бага зэрэг ялгаатай бөгөөд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт нь уян хатан байдаг. Ийм энгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй зах зээлийн хүчтэй өрсөлдөөн болон технологийн хуучралт нь гол эмзэг асуудал нь болж байдаг.




- Niche-ялгарах стратеги: Энэ стратеги нь зах зээлийн өчүүхэн бага хэсэг болон хэрэглэгчдийн нарийн хүрээний онцгой хэрэгцээнд зориулсан ялгаатай, хэрэгцээг бүрэн хангаж чадахуйц бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгодог бизнесийн нэгжид тохиромжтой. Энэ зах зээл нь эрэлт нь бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд уян хатан биш бүтээгдэхүүн үйлчилгээ нь өндөр үнэтэй байдаг. Уг стратегийг хэрэглэж буй байгууллагын өрсөлдөөний гол хүчин зүйл нь шинэ бүтээгдэхүүнийг бий болнох, эсвэл тэдэнд тасралтгүйгээр хариу үзүүлэхийг чармайхад оршдог.



- Niche- бага зардлын ялгарах стратеги: Энэ стратегийг зардлыг бага байлгаж зах зээлийн өчүүхэн бага хэсэг болон хэрэглэгчдэд хэрэгцээг нь бүрэн хангаж чадахуйц ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгон өрсөлддөг бизнесийн нэгжүүд баримтална. Энэ хоёр зүйлийг нэгэн зэрэг хэрэглэх дараах арга замуд байдаг. Үүнд:



- Чанарт бүр зүйлээ зориулах
- Процессийн шинэчлэлт
- Бүтээгдэхүүний шинэчлэлт
- Систесийн шинэчлэлт



- **Бага зардлын стратеги:** Бага зардлын стратегийг баримталж буй бизнесийн нэгж нь энгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэдэг бөгөөд нийт зах зээлийн үнийн мэдрэмжтэй хэрэглэгчдэд ханддаг байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь бусад бизнесээс бага зэрэг ялгаатай байх ба зах зээлийн эрэлт нь уян хатан байдаг. Зах зээлийн томоохон хэсэгт их хэмжээний үйлдвэрлэл явуулсанаар нэгжийн зардлыг бууруулахад энэ стратегийн мөн чанар оршино.
- **Ялгарах стратеги:** Энэ стратегийг баримталж буй бизнесийн нэгж нь цорын ганц бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг бөгөөд харьцангуй уян хатан эрэлттэй том зах зээлд ханддаг байна. Хэрэглэгчид нь ерөнхийдөө цорын ганц тэрхүү бүтээгдэхүүнд дундаас дээгүүр үнэ төлөхөд бэлэн байдаг. Учир нь хэрэглэгчид нь харьцангуй үнийн мэдрэмж бага байдаг. Функционал нэгж бүрийн чанарын асуудлыг чухалчлан үздэг.
- **Бага зардал-ялгарах стратеги:** Байгууллага нь ихэнхдээ том хэмжээтэй үнийн мэдрэмжгүй зах зээлд цорын ганц бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг бол энэ стратегийг баримталдаг. Бага зардлаар ялгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжүй гэж зарим онолчид үздэг.
- **Хосолсон стратеги:** Энэ стратегийн сөн чанар нь байгууллагын бизнесийн нэгжүүд дээрх стратегиудийг хослуулан хэрэглэхэд оршдог.

## Функционал стратеги

Нэгдсэн түвшний стратегийг хэрэгжүүлэхэд бизнесийн нэгж дэх функционал хэсгүүдийн стратеги, зорилго чухал үүрэгтэй. Функционал нэгж бүр нь өөр өөрийн зорилготой боловч өөрсдийн үйл ажиллагааг уялдуулан зохицолдуулж байж байгууллагын нэгдсэн зорилгод хүрнэ. Аливаа бизнесийн байгууллагуудад дараах функционал нэгжүүд байдаг. Үүнд:

Худалдан авалт: Энэ функционал нэгж нь боломжит нийлүүлэгчдийг тодорхойлох, тэднийг үнэлэх, олж авах, үнийн хэлцэл хийх, захиалгын хэмжээг тохирох, түүний эд материалыг татан авах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Niche-бага зардал болон бага зардлын стратегийг баримталж байгаагаас үл хамааран бага зардлаар худалдан авалт хийхийг эрмэлздэг. Гэвч хямд үнэ нь худалдан авалтын цорын ганц гол анхаарах зүйл биш бөгөөд чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд үнэтэй орцыг худалдан авах шаардлагатай.

Үйлдвэрлэл үйл ажиллагаа: Энд үндсэн нөөцүүдийг ашиглан орцыг гарц болгон хувиргах бүхийл үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үндсэн зорилго нь бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардлагатай орц болон түүнийг хувиргах процессын өртөг зардлыг зохистой хэмжээнд байлгаж үр ашигтай үйлдвэрлэлийг бий болгоход оршино.

Хүний нөөц: Хүний нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь чадварлаг ажиллах хүчийг бүрдүүлэн тэднийг тогтвортой ажиллуулж идэвхжүүлэх явдал байдаг бөгөөд боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, бүрдүүлэх, хүмүүсийг ажлын байранд нь хуваарилах, гүйцэтгэлийг үнэлэх, тэднийг сургах, цалин хөлсийг тогтоох, ажлын орчинг сайжруулах зэрэг функцуудыг хэрэгжүүдлэг.

## Функционал нэгжүүдийн хамтын ажиллагаа

Стратегийн амжилт нь ерөнхийдөө функционал нэгжүүдийн нягт хамтын ажиллагаагны үр ашгийг шаарддаг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа нь аажмаар нэгээс нөгөөтэй уялдан зохицуулагддаг байна. Энэ нь дараах нөхцлүүдээр тайлбарлагддаг. Үүнд:

- Дотоод нэгдэл: Бүх функционал бодлогууд нь нэг нэгнээ нөхцөлдүүлж, бүрдүүлж байх ёстой.
- Тэнцвэржүүлэлт: Нэг нэгжийн бодлого нь нөгөөгөө дэмжих чиглэлээр уялдаатайгаар боловсруулагдах ёстой.
- Нягт холбоо: Функционал нэгж бүрийн үйл ажиллагаа нь байнгын холбоо хамааралтай, зохицуулалттай байх нь нэгдсэн бодлогын интеграцид нөлөөлдөг.
- Цаг хугацаа: Функционал стратеги нь бүх чиглэлээр цаг хугацааны хувьд логик дэс дараалалтай боловсруулагдаж хэрэгжих ёстой.

### 1.1.6. Стратегийн хэрэгжүүлэлт

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудал нь байгууллагын дотоод удирдлагын асуудал байдаг. Стратегийн хэрэгжилт нь ажил үүргийн зохион байгуулалт, сэдэл, соёлын хүчин зүйлс, манлайлал зэргийн хоорондох тууштай нийцлийг бий болгосон зэргээс хамаардаг. Стратегийг хэрэгжүүлэх нь томъёолохоос нэлээд хүнд, цаг хугацаа илүү зарцуулдаг бөгөөд үүний тулд удирдлага нь стратегийнхаа мөн чанарыг сайтар ойлгосон байх ёстой. Стратегийг хэрэгжүүлэх явдал нь зөвхөн дэд удирдлагын ажил биш удирдлагын бүхэл багийн ажил болно.

Стратегийн амжилттай хэрэгжүүлэлтийг тодорхойлох хүчин зүйлсийн нэг нь хэрэгжүүлэлтийн үйл явцыг удирдлага нь хэр сайн удирдаж байгаа явдал юм. Мөн байгууллагын гадаад дотоод орчин, түүний нөхцөл байдал нь стратегийн хэрэгжилтийн үед удирдлагад бэрхшээл учруулж байдаг.

Стратегийн хэрэгжилтийн үйл явцыг удирдлагын зургаан бүрдэл хэсэгт хуваан авч үздэг<sup>10</sup>. Үүнд:

- Зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох
- Стратегийг дэмжих төсвийг боловсруулах
- Удирдлагыг дэмжих системийг суулгах
- Зорилго ба стратегийн гүйцэтгэлтэй урамшууллыг холбох
- Стратегийг дэмжих байгууллагын соёлыг бий болгох
- Стратегийн манлайлал хэрэглэх зэрэг болно

Стратеги ба бүтцийн нийцэл

Байгууллагын стратегитай бүтэц нь нийцэж байх ёстой. Стратеги бүр амжилтын гол хүчин зүйл, шийдвэрлэх гол ажлуудын бүрдлийг тогтоох үндэс болдог. Байгууллагын стратеги зорилготой холбоотой амжилтын гол хүчин зүйлсийн нэг нь стратегийг дэмжих байгууллагын бүтцийг бий болгох явдал юм. Стратегитай бүтцээ нийцүүлэх явдал нь стратегийн гол ажлыг хийх нэгжүүдийг байгууллагын бүтцэд бий болгохыг шаарддаг. Стратегитай бүтцээ нийцүүлэхэд Стратегийн гол үйл ажиллагаануудыг нарийн тодорхойлох, Үйл ажиллагаануудын хоорондох хамаарлыг ойлгох, Байгууллагын нэгжид үйл ажиллагааг бүлэглэх, Нэгжүүдийн эрх мэдэл, бие даасан байдлыг тодорхойлох, Нэгжүүдийн хооронд зохицуулалтаар хангах зэрэг 5 процедурыг хэрэглэдэг.


Стратеги болон соёлын нийцлийн үнэлэх

<sup>10</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 106, УБ 2011

Байгууллага хэрэв шинэ стратеги хэрэгжүүлэхээр болсон бол стратеги болон соёлын нийцлийг үнэлэх хэрэгтэй. Стратегийг үнэлэхдээ дараах асуултуудад хариулт өгөх шаардлагатай<sup>11</sup>. Үүнд:

- Төлөвлөсөн стратеги нь байгууллагын өнөөгийн стратегитай нийцсэн эсэх.
- Шинэ стратегитай илүү нийцүүлэхийн тулд соёлыг хялбар өөрчилж болох эсэх.
- Удирдлага нь байгууллагын чухал өөрчлөлтүүдийг хийх болон саад бэрхшээл, зардлын өсөлтийг хүлээн зөвшөөрч яадах эсэх.
- Удирдлага нь стратегийг бүрэн гүйцэд хэрэгжүүлж чадах эсэх.

Схем 8. Стратеги – соёлын нийцлийн үнэлгээ<sup>12</sup>



### Стратегийн манлайлал

Стратегийн манлайлал нь нөхцөл байдлаа шинжлэн судлах, түүнийг удирдах арга замуудаас сонголт хийх явдал байдаг. Хүчтэй удирдлага нь үр ашигтай стратеги хэрэгжүүлэлтийн салшгүй хэсэг нь байдаг. Стратегийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааг хэлэлцэх үед манлайллын дараах зургаан үүрэг давамгайлж байдаг. Үүнд:

<sup>11</sup> Thomas L. Wheelen, J. David Hunger. Strategic management. Page 215 Addison-Welsey, 1998.

<sup>12</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 134, УБ 2011


- Юу ч тохиолдож байсан, ажлаа хэдий сайн хийж байсан ч дээд удирдлага нь удирдлага хэвээр байх
- Өндөр түвшинд гүйцэтгэх, стратегийг хэрэгжүүлэхэд байгууллагыг эрчимжүүлсэн тийм соёлыг дэмжиж тэтгэх
- Нөхцөл байдлын өөрчлөлтөнд хариу арга хэмжээ авч байгууллагаа хамгаалах, шинэ боломжийн хувьд бэлэн байдалд байх, шинэ санал санаачлагыг дэмжих
- Стратегийг томъёолох, хэрэгжүүлэх бодлогыг шийдэх, тохиролцоог бий болгох, эрх мэдлийн тэмцлийг дарах
- Ёс суртахууны стандартыг бэхжүүлэх
- Стратегийн хэрэгжүүлэлт ба ерөнхий стратегийн гүйцэтгэлийг дээшлүүлэхдээ засварлах арга хэмжээг авах.

Хэрэгжүүлэлтийн үйл явцыг сайн явуулахдаа удирдлага нь харилцаа ба мэдээллийн эх үүсвэрийн албан болон албан бус өргөн сүлжээг хөгжүүлэх хэрэгтэй. Нөхцөл байдлын талаар нарийн мэдээлэлтэйбайж, мэдээллийг авах зөв арга хэрэглэх шаардлагатай.

### 1.1.7. Стратегийн хяналт

Удирдлага нь хяналтын системийг бий болгохдоо хяналт нь стратегийг дагадаг гэдгийг санах ёстой. Байгууллага үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгохын тулд хяналт нь дараах шинж чанаруудыг агуулсан байх ёстой. Үүнд:

- Хяналтыг явуулахад маш товч бөгөөд тодорхой мэдээллийг хэрэглэх шаардлагатай бөгөөд амжилтыг шийдвэрлэх хүчин зүйлсд төвлөрсөн байх ёстой.
- Хяналт нь зөвхөн чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болон үр дүнг хянах хэрэгтэй.
- Хяналт нь цагаа олсог байх ёстой. Учир нь хоцрохоос нь өмнө зөв өргө хэмжээ авах ёстой бөгөөд гүйцэтгэлд нөлөөлөх гол хүчин зүйлсийг хэмжих хэрэгтэй
- Урт болон богино хугацааны хяналтыг ашиглах хэрэгтэй. Богино хугацааны үнэлгээг онцолж байвал богино хугацааны чиг хандлага тохирно.
- Хяналт нь шаардлагагүй зүйлсийг нарийн тодорхойлоход чиглэнэ.
- Стандартаас илүүтэйгээр гарсан гүйцэтгэлийг хэмжих урамшуулах ёстой.

Схем 9. Стратегийн хяналтын процесс<sup>13</sup>

## 1.2. Уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөө түүний онцлог

Уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөө нь маш онцлог тул түүнийг судлахын тулд уул уурхайн салбар мөн салбарын ерөнхий стратегийн талаар судлах хэрэгтэй. Уул уурхайн салбар нь маш их онцлогтой салбар бөгөөд манай улсын эдийн засагт эзлэх байр суурь нь маш өндөр байдаг. Мөн манай улсын хувьд уул уурхайн салбарын нь байгалын баялагын багтаамж ихтэй нь бөгөөд энэ нь уул уурхайн салбарын нийт оруулж буй орлого нийт олборлож хэрэглэж буй байгалын баялагын харьцаа маш их байгаагаас харагдаж байна. Мөн уг салбарт тулгамдаад байгаа асуудал нь эцсийн бүтээгдэхүүн буюу оюуны болон технологийн багтаамж ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх болоод байгаа бөгөөд уг салбарт ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай мөн маш их хөрөнгө оруулалт шаарддаг салбар юм.

Үүнтэй холбоотойгоор эрдэмтэн судлаачид монгол улсын уул уурхайн салбарын хөгжлийн шинэ зууны стратегийг боловсруулан гаргасан байна<sup>14</sup>. Үүнд:

- Уул уурхайн салбарын шинжлэх ухаан боловсролыг хөгжүүлэх
- Геологи хайгуулын ажлын хэмжээг ашигт малтмалын нөөцийг ашигласан хэмжээнээс наад зах нь 2 дахин илүү байхаар бодож нэмэгдүүлэх шаардлагатай
- Уул уурхайн салбарын түүхий эдийг олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн технологийг боловсронгуй болгох.
- Уулын технологийн трансформаци

<sup>13</sup> Д.Оргилон, “Стратегийн удирдлага”, хуудас 162, УБ 2011

<sup>14</sup> П.Очирбат, Л.Пүрэв, Ж.Лхамсүрэн, Д.Чулуун, Сун Юун Сонь, “Монгол орны геологи уул уурхайн ном”, хуудас 210-214, УБ 2008

- Эдийн засгийн нээлттэй харилцааны нөхцөл дэх банк санхүүгийн зах зээлд чөлөөтэй ажиллах, технологи шилжүүлэх, хөрөнгө оруулах хүрээний хамтын ажиллагаа байх ёстой.
- Уул уурхайн салбарын нөөцийн шинэ шинэ эх үүсвэр, шинэ төрлийг эрж хайх, эзэмших хөрөнгө оруулалтын стратеги
- Уул уурхайн салбарын нөөц чадавхаа бүрэн гүйцэд, иж бүрэн ашиглах.
- Технологийн трансформаци ба инноваци хийх замаар нөөц хэмнэх, хаягдал, бохирдолт багатай экотехнологи нэвтрүүлэх
- Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
  - Бүтээгдэхүүний чанар
  - Экологийн цэвэр бөгөөд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн түвшин
  - Үнэ

#### 1. Улсаа баяжуулж, ард түмнийхээ амьдралын чанарыг дээшлүүлэх

Гэх мэт дээрх стратегиуд байгаа бөгөөд эдгээр стратегиудыг хэрэгжүүлэхэд 3 төрлийн хязгаарлалт байх ёстой<sup>15</sup>. Үүнд:

- Экологийн хязгаарлалт
- Эдийн засгийн түүхий эдийн багтаамжийг багасгаж оюуны багтаамжийг нэмэгдүүлэх
- Хөгжлийн аж үйлдвэржилтийн загварыг экотехнологийн загварт түлхүү шилжих зорилтоос урган гарах хязгаарлалт зэрэг байх болно.

#### 1.2.1. Уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөөний онцлог

Уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөөний онцлогыг гаргаж ирхийн тулд эхлээд уул уурхайн байгууллагын онцлогыг тодорхойлох хэрэгтэй. Уул уурхайн байгууллага нь бусад байгууллагуудаас ихээхэн өөр байдаг бөгөөд уг бизнест ороход их хэмжээний хөрөнгө шаарддаг мөн үйл ажиллагаа явуулахад ч маш их хэмжээний хөрөнгө шаарддаг. Мөн уул уурхайн бүтээгдэхүүний үнэ нь дэлхийн зах зээлийн үнээс хамаарч тогтдог, бүтээгдэхүүн хэрэглэгчид нь тогтсон нэг хэрэглэгч, бүтээгдэхүүний эрэлт хангалттай, маркетингийн үйл ажиллагаа хэрэггүй, мэргэжлийн мэргэшсэн ажилчид ихээр шаардагддаг, гаргаж буй бүтээгдэхүүн нь тогтсон нэг чанар стандарт бүхий бүтээгдэхүүн байдаг, өөрийн дотоод үр ашигтаа чиглэсэн менежментийн үйл ажиллагааг түлхүү авч

<sup>15</sup> П.Очирбат, Л.Пүрэв, Ж.Лхамсүрэн, Д.Чулуун, Сун Юун Сонь, “Монгол орны геологи уул уурхайн ном”, хуудас 215, УБ 2008

хэрэгжүүлдэг, гаргаж буй бүтээгдэхүүнийхээ өртөг зөрдлыг бууруулхад чиглэж ажилладаг, хууль эрх зүйн маш олон зоцшицуулалтан зохицож үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай болдог зэрэг онцлогуудтай байдаг.

Уул уурхайн байгууллага нь стратеги төлөвлөгөө боловсруулахдаа гадаад орчны нөлөөлөл болон өөрийн дотоод үйл ажиллагаагаа үнэлсэний үндсэн дээр боловсруулдаг бөгөөд дотоод үйл ажиллагаандаа чиглэсэн стратегитай байдаг. Үүнд:

- Нэгдэх ба нэгтгэх
- Холбоо тогтоох /худалдан авагч, нийлүүлэгч/
- Бүтээмжийг нэмэгдүүлэх
- Хүчин чадлаа нэмэгдүүлэх
- Нэмүү өртөг шингсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Зардлаа бууруулах
- Хувьцаа эзэмшигчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, ашиг сонирхолыг хамгаалах
- Чадварлаг мэргэшсэн ажиллах хүчнийг өөртөө татах
- Бүтээгдэхүүний чанар стандартыг сайжруулах
- Бүтээгдэхүүн тээвэрлэлт
- Хаягдал, бохирдолтоо бууруулах зэрэг үндсэн ерөнхий стратегиудыг баримталдаг.



### 1.3. КРІ гэж юу вэ?, Стратеги төлөвлөгөөг КРІ-тай уялдуулах

КРІ буюу Key Performance Indicator-г монгол хэлнээ Гүйцэтгэлийн гол үзүүлэлт буюу ГГҮ гэж утгачилан орчуулдаг. КРІ гэдэг нь аливаа ажил үүрэг, төлөвлөлт зэрэг зүйлсийн гүйцэтгэлийг үнэлэдэг үзүүлэлт юм. КРІ-г ихэнх хүмүүс зөвхөн хүний нөөцийн үнэлгээний арга гэж үздэг. Гэвч КРІ- бүхийл зүйлийг үнэлж болдог бөгөөд энэ арга нь үнэлгээний цогц арга юм.

СГЗШ, ГГҮ гэж юу вэ?

КРІ гэдэг нь компаний, хэлтэс, газрын, багийн болон хувь хүний гүйцэтгэлийг тодорхойлох аргачилал ба бизнес стратегитай харилцан уялдаа холбоотой байдаг. ГГҮ-г олон тооны байгууллагууд гүйцэтгэлийг үнэлэхдээ ашигладаг. СГЗШ ( Стратегийн Гол Зорилтын Шалгуур) нь бизнесийн стратегийн гүйцэтгэлийн чанарыг хэмжих тоон үзүүлэлт юм. ГГҮ нь бизнес төлөвлөгөөний чухал индикатор ба СГЗШ-ийг хувирган ГГҮ болгож тодорхойлдог.

Бизнесийн Стратеги ба СГЗШ, ГГҮ-г Тайлбарлах нь

Бизнесийн стратеги боловсруулахад хувь хариуцах нэгжийг /газар, хэлтэс, баг, хувь хүн/ тодорхойлох нь чухал байдаг. Учир нь эдгээр нэгжүүд нь өөрсдийн бизнес стратегийг тодорхойлж, түүнтэйгээ уялдах ГГҮ-ээ тодорхойлж түүнд хүрэх үйл ажиллагаа явуулдаг. “Өөр өөр байр сууринаас тодорхойлсон Бизнесийн стратеги болон ГГҮ-ийн жигсаалт” хэмээх хүснэгтийг бизнес төлөвлөгөө, СГЗШ, ГГҮ-үүдийг өөр өөр байр сууринаас тодорхойлож дүгнэхэд ашигладана (санхүү, зах зээл/хэрэглэгч, бизнесийн процесс, сургалт, хөгжил ба хүний нөөц). Богино болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд энэ хүснэгтийг тус тусд нь ашиглана.

СГЗШ/ГГҮ -г тодорхойлох гол асуудлууд<sup>16</sup>

КРІ буюу ГГҮ нь АХ, ЭЗ, ҮЗ, БЗЗ ба стратегийн хэрэгжилтийн хэмжүүр юм. КРІ-аар зорилго тодорхойлсоноор биелэлтээ бодитоор, тоогоор илэрхийлэх боломжтой.

<sup>16</sup>“Бизнес төлөвлөгөө боловсруулахад зориулсан гарын авлага” Орчуулсан Ч.Ундрам Г.Цэрэн УБ 2010 он

СГЗШ/KPI-ийг тогтооход анхаарах зүйлс:

1. СГЗШ/ГГҮ нь тодорхой байх (хэмжигдэхүйц, хянахуйц, биелэгдэхүйц), компани даяар нэгдмэл байдалтай байх : SMART.
2. СГЗШ/ГГҮ –ийг 4 үндсэн байр суурьтай холбож, SWOT/Cross-SWOT шинжилгээ ба CSF (Critical Success Factor)-Амжилтын чухал хүчин зүйлс–ийн шинжилгээгээр тодорхойлогдсон дотоод/гадаад орчныг бүрэн илэрхийлсэн байвал зохино.
3. СГЗШ/ГГҮ дараах нөхцлийг хангасан байвал зохино:  
  
“Суралцах, хөгжих” ба “Бизнес процесс” -ийн чиглэлээр тавьж байгаа хүчин чармайлт нь “Хэрэглэгчийн байр суурь”-тай нягт уялдаатай байж, эцэстээ, “Санхүүгийн байр суурь”-наас тавьсан зорилгуудыг биелүүлсэн байх.
4. СГЗШ/ГГҮ –ийг компаний түвшингээс хувь хүн хүртэл хэлтэс, тасаг, багаар нь дамжуулах хүргэвэл зохино.
5. СГЗШ/ГГҮ –ийг “Бизнес процесс” ба “Суралцах, хөгжих” чиглэлээр тодорхойлохдоо Бизнес процессын урсгал—ыг ашиглавал зохино.

ГГҮ-г түгээх нь



Схем 10. Байгууллагын ГГҮ-н түвшин<sup>17</sup>

Компаний Бизнесийн Стратеги, СГЗШ болон ГГҮ

<sup>17</sup> “Бизнес төлөвлөгөө боловсруулахад зориулсан гарын авлага” Орчуулсан Ч.Ундрам Г.Цэрэн УБ 2010 он

Санхүүгийн байдал				
Бизнесийн стратеги	СГЗШ (Стратегийн Гол Зорилтын Шалгуур)	ГГҮ (Гүйцэтгэлийн Гол Үзүүлэлтүүд)		Хариуцах нэгж, алба, хэлтэс, ажилчин
		ГГҮ зүйл	ГГҮ Зорилт	
Зах зээл/Хэрэглэгчийн байдал				
Бизнесийн стратеги	СГЗШ (Стратегийн гол зорилтын шалгуур)	ГГҮ (Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд)		Хариуцах нэгж, алба, хэлтэс, ажилчин
		ГГҮ зүйл	ГГҮ Зорилт	
Бизнес процессын төлөв байдал				
Бизнесийн стратеги	СГЗШ (Стратегийн гол зорилтын шалгуур)	ГГҮ (Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд)		Хариуцах нэгж, алба, хэлтэс, ажилчин
		ГГҮ зүйл	ГГҮ Зорилт	
Сургалт ,Хөгжил ба хүний нөөцийн байдал				
Бизнесийн стратеги	СГЗШ (Стратегийн гол зорилтын шалгуур)	ГГҮ (Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд)		Хариуцах нэгж, алба, хэлтэс, ажилчин
		ГГҮ зүйл	ГГҮ Зорилт	

Хүснэгт 2. Компанийн бизнесийн стратегийн ГГҮ-н хүснэгт<sup>18</sup>

Хувь хүн болон хэлтэсийн ГГҮ

Газрын KPI				Хариуцсан хүний нэр:	
				Хариуцсан хүний KPI	
SKGI	KPI зорилго	KPI тоон үзүүлэлт	Хариуцсан хүний нэр	KPI зорилго	KPI тоон үзүүлэлт

Хүснэгт 3. Хувь хүн болон хэлтэсийн ГГҮ

<sup>18</sup> “Бизнес төлөвлөгөө боловсруулахад зориулсан гарын авлага” Орчуулсан Ч.Ундрам Г.Цэрэн УБ 2010 он

## Хоёр. УУЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛЖ КРІ-ТАЙ УЯЛДУУЛАХ НЬ

### 2.1. Уул уурхайн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах нь

#### 2.1.1. ХХК-н танилцуулга, үйл ажиллагаа

ХХК нь ..... төмрийн хүдрийн орд газарт нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг үндэслэн “.....”-ны төмрийн ил уурхайг ашиглах ТЭЗҮ боловсруулан холбогдох газруудаар батлуулж 2007 онд уурхайн үйл ажиллагааг эхлүүлсэн.

“.....”-ны төмрийн ил уурхайд 4.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж жилд 360,0 мян.тн хүдэр олборлож 200,0 мян.тн төмрийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай байгуулагдсан.

Уурхайн бүтэц зохион байгуулалт:

- Баяжуулах үйлдвэр
- Уулын хэсэг
- Өрөмдлөг тэсэлгээний хэсэг
- Дорнод дахь төлөөлөгчийн газар гэсэн бүтэц зохион байгуулалттай нийт 50 гаруй ажилтан, ИТА нартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Уурхай нь өөрийн хөрөнгөөр ..... хотын ..... төмөр замын өртөөнд баяжмал ачих талбай байгуулсан ба уурхай хүртэл 120 км сайжруулсан шороон замаар холбосон.

Тайлант 2010 оны 4-р сарын 15-наас 11-р сарын 20 хүртэлхнийг 7 сарын хугацаанд тус уурхайн уулын хэсэг нь хөрс хуулалт, хүдэр олборлолтонд Hyundai 450LC-7 маркийн 2,5 м<sup>3</sup> шанагатай экскаватор нэг ширхэг, 30 тн даацтай автосамосвал 4 ширхэг, Komatsu 155A маркийн бульдозер зэрэг 7 нэгж уулын техник тоног төхөөрөмж тэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн зорилго, зорилтууд

“” ХХК нь чадварлаг боловсон хүчин болон шилдэг техник технологи ашиглан орчин үеийн хариуцлагатай уул уурхайн компанийг бий болгох нь уг компаний эрхэм зорилго юм.

..... уурхайн зорилго зорилтууд нь 2015 оныг хүртэл уурхайн хэвийн үйл ажиллагааг хангах, олборлолт баяжуулалтыг нэмэгдүүлж ашиг орлогыг нэмэгдүүлэхэд оршино. Үүнд.

- Уурхайг цахилгаан шугамд холбох
- Хаягдал хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах
- Уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх

Зэрэг томоохон зорилго зорилтууд байгаа бөгөөд эдгээрийг ойрын хугацаанд хэрэгжүүлж эхлэхээр байна.

#### Компанийн хөгжлийн ирээдүй

“” ХХК-н хөгжлийн ирээдүй нь орон нутгийн хөгжилтэй ихээхэн холбоотой юм. Уг уурхайн тогтоогдоод байгаа нөөцийн хэмжээ 9 саят онн байгаа бөгөөд нарийвчилсан хайгуулын ажил хийгдээгүй их хэмжээний талбай байгаа бөнгөөд хайгуулын ажлыг бүрэн хийж дуусхад тогтоогдоогүй нөөцийн хэмжээ тодорхой болох юм.

..... уурхайн хувьд дотоодын хүчин чадлаараа ажиллавал уг нөөцийг бүрэн олборлож дуусахад маш их хугацаа шаардах бөгөөд цаашдаа хүчин чадлаа ихээхэн нэмэгдүүлнэ.

#### 2.1.2. “” ХХК-н стратеги төлөвлөлт

Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад зах зээлийн хүчин зүйлс, үнэлгээ

Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад зах зээлийн хүчин зүйлс:

1. Валютын ханшны өөрчлөлт
2. Төмрийн хүдрийн эрэлт
3. Төмрийн хүдрийн үнэ
4. Хууль эрхзүйн өөрчлөлт /импортлогч орны гаалийн татвар, хоригсаад, гэх мэт/
5. Төмөр зам, тээвэрлэлт
6. Хятад улсын гангийн зах зээл

#### 3.1.1 Валютын ханшны өөрчлөлт:

Сүүлийн жилүүдэд валютын ханш эдийн засгийн хямралаас болж ихээхэн хэлбэлзэлтэй байна. 2011 оны хувьд Төгрөг болон Америк Долларын ханш харьцангуй тогтвортой байх ба төгрөг ба зэрэг чангарах хандлагатай байна гэж үзэж байгаа бол

голимпортлогч орон болох хятадын мөнгөн тэмдэгт юуаны хувьд төгрөг болон америк доллартай харьцах харьцаа нь чангарах хандлагатай байна.

#### Төмрийн хүдрийн эрэлт:

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр төмрийн хүдрийн эрэлт тогтмол өсөж байна. Үүнээс 2010 онд дэлхийн нийт төмрийн хүдрийн хэрэглээний 62,5%-ийг хятадын зах зээл дангараа хэрэглэж байна. Мөн дэлхийн бүх төмрийн хүдрийн нөөцийн 9,7% нь хятад улсад байдаг боловч агуулга нь маш бага байдаг тул тэрхүү нөөцөө ашиглаж чадахгүй байна. Хятадын төмрийн хүдрийн хэрэглээ жилд 10 орчим хувиар тогтмол өсөж байна. Мөн хэрэглээгээрээ дээгүүрт орж байгаа зүүн хойд азийн орнууд Япон, Солонгос зэрэг улсууд манай улстай маш ойр байна. Эдгээр улсууд нь хэрэглээнийхээ ихэнхийг Африк, Латин Америк, Энэтхэг зэрэг улс орнуудаас хангаж байна. Ингэхдээ тээврийн зардал их өртөг өндөртэй баяжмалыг хэрэглэж байна. Иймээс тээврийн зардал өртөг бага агууламж өндөртэй баяжмал авах сонирхол их байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд эдгээр улсуудын хөрөнгө оруулалттай уулуурхайн компаниуд манай улсад ихээр байгуулагдаж байна. Мөн 2010 онд дэлхийн улс орнуудын төмрийн хүдрийн нийт хэрэглээ 7%-аар өссөн байна. Иймээс 2011 онд мөн төмрийн хүдрийн эрэлт өсөх магадлалтай байгаа нь эрэлтийн хувьд үйл ажиллагаанд нөлөөлөхөөр ноцтой асуудал болж чадахгүй.

#### Төмрийн хүдрийн үнэ:

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр төмрийн хүдрийн баяжмалын үнэ огцом өсөж байна. Төмрийн хүдрийн баяжмалын дэлхийн зах зээлийн үнэ 180-200\$ байхад манай улсад төмрийн хүдэр борлуулах үнэ нь 65-70\$ байна. Мөн төмрийн хүдрийн үнийг 130-140\$ буюу 2 дахин өсгөх боломж байгаа нь харагдаж байна. Дэлхий нийтийн гангийн үйлдвэрлэл нэмэгдэж байгаа байдал, Төмрийн хүдрийн гол импортлогч Хятадын эрэлт хэрэгцээ ба төмрийн хүдрийн нийлүүлэлтийн хэмжээнээс шалтгаалан 2011 онд төмрийн хүдрийн үнэ нилээд өсөх хандлагатай байна. Бэлэн зарагдах төмрийн хүдрийн үнэ 2011 оны эхнээс эхлэн нэмэгдэж байгаа ба 2-р улиралд зарагдах төмрийн хүдрийн гэрээний үнэ 165 ам.доллар/тн-д хүрч цаашид ч өсөх шинжтэй байна. Энэтхэг улс төмрийн хүдрийн экспортоор дэлхийд 3-т ордог бөгөөд дотоодын гангийн хэрэглээндээ зориулахаар экспортоордоо хориг тавьж байгаа нь төмрийн хүдрийн нийлүүлэлтийг багасгаж үнэ нэмэгдэхэд нөлөөлж байна. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй хятадын хөрөнгө оруулалттай компаниуд зохиомлоор хүдрийн үнийг унагах үйл ажиллагаа байнга явуулж байна. Тэдгээр компаниуд нь төмрийн хүдрийн

баяжталаа өөрийн оронд гаргахдаа баяжмалын нийт зардлааг нь гаргаж байгаа бөгөөд монгол болон бусад улсын хөрөнгө оруулалттай компаниуд баяжмал гаргахад үнийг зохиомлоор унагааж маш хямдаар авах сонирхолтой байна.

### Төмрийн хүдрийн үнэ



Эх сурвалж: Ашигт малтмалын ерөнхий газар: / [mram.gov.mn](http://mram.gov.mn) / [kitco.com/](http://kitco.com/)

#### Тээвэрлэлт:

Дэлхийн томоохон экспортлогч орнууд нь тээвэрлэлтээ дийлэнхийг нь далайгаар тээвэрлэдэг бөгөөд өртөг зардал нь маш бага байдаг хэдий ч ихэвчлэн урт хугацаагаар хол газарлуу тээвэрлэдэг. Манай орны хувьд далайд гарцгүй хэдий ч гол экспортлогч орнуудтай газарзүйн хувьд ойр оршиж байгаа нь тээвэрлэлтийн хүндрэлийг багасгаж байна. Уг уурхай нь Чойбалсан хотын Баянтүмэнгийн төмөр замын өртөө хүртэл 120 км зайтай бөгөөд сайжруулсан шороон замтай уг өртөөнд баяжмал ачих талбайтай. Уг өртөөнөөс төмөр замаар БНХАУ-н хил хүртэл 220 км зайтай бөгөөд төмөр замаар баяжмалаа тээвэрлэнэ.

#### Хууль эрх зүй:


Гол хэрэглэгч улс болох орос болон хятад улсын хувьд сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хууль тогтоомжоо шинэчлэн найруулж хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна. Энэ онд Япон, Солонгос, БНХАУ болон ОХУ-

ын хувьд экспортын болон гаалийн албан татвар, төмрийн хүдэртэй холбоотой бусад татварууд нь харьцангуй тогтвортой байна гэж таамаглаж байна.

#### Хятад улсын гангийн зах зээл

Дэлхийн төмрийн хүдрийн зах зээл нь гангийн зах зээлээ дагаж байдаг ба ган үйлдвэрлэгч томоохон улс орнуудын гангийн зах зээлд тулгуурлаж байна. Хятад улс нь ган үйлдвэрлэл, гангийн экспортоороо дэлхийд тэргүүлж байна. Азын улс орнуудын хувьд 2008-2009 онд гангийн экспорт 140.8 – 97.6 сая тонн болж 31 хувиар буурсан байна. Энэ нь дэлхийн эдийн засгийн хямралтай холбоотой. 2008-2009 онд Хятадын хувьд 56.2 - 21.7 сая тонн болж 61 хувиар буурсан байна. Үүнийг дагаад хятад улсын гангийн импорт 15.4 – 22 сая тонн болж өссөн байна. Олон улсын хэмжээнд ган үйлдвэрлэл 2010 оны эхний найман сарын байдлаар 931.98 сая тоннд хүрсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад энэ нь 21.9 хувиар өссөн ба Хятад улсын хувьд ган үйлдвэрлэл нь 15.3 хувиар нэмэгдсэн.

\*- Азын орнуудын 2001-2010 оны түүхий гангийн үйлдвэрлэл



Азын зах зээлд хятад улсын гангийн үйлдвэрлэл тогтмол өссөөр 2001 онд 151.6 сая тонн буюу 42.7% эзлэж байсан бол 2010 онд 626.7 сая тонн буюу 69.8% болж өссөн байна. Харин бусад орнуудын хувьд тогтмол бага зэргийн өсөлттэй байна.

Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх эдийн засаг, улс төр, нийгмийн хүчин зүйлс, үнэлгээ



Эдийн засгийн нөлөөлөл:

Манай орны хувьд стратегийн орд газрууд болох “Оюу Толгой”, “Таван толгой” зэрэг дэлхийд томоохонд тооцогдох орд газруудыг ашиглан эргэлтэнд оруулж эхлэснээр мөнгөн хөрөнгийн урсгал манай орныг чиглэх таатай нөхцөл бүрдэж байгаа билээ. Өнөөдрийн байдлаар тус салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 18 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71.3 хувь, экспортын орлогын 77.1 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд энэ салбар үсрэнгүй хөгжиж байна.

Улс төр, хууль эрх зүйн хүчин зүйлс:

Одоогоор Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийт 63 136,7 мян.гектар талбайд 1086 ашиглалтын, 5835 хайгуулын тусгай зөвшөөрлийг гадаадын хөрөнгө оруулттай 236 аж ахуйн нэгж, дотоодын 1762 аж ахуйн нэгж, хувь хүн, хамтарсан хөрөнгө оруулалттай 147 аж ахуйн нэгж тус тус эзэмшиж байна. Гадаадын хөрөнгө оруулагчдаас хамгийн олон тусгай зөвшөөрлийг Их Британи, Япон, ОХУ, БНХАУ-ын хөрөнгө оруулагчид эзэмшиж байна. Хамгийн олон тусгай зөвшөөрөл авсан өндөр хөгжилтэй гадаадын 10 улсын хөрөнгө оруулагчид нийт зөвшөөрөлтэй талбайн 58 орчим хувьд үйл ажиллагаа явуулж байгаа нь дахин шинэ орд газар нээгдэх магадлалыг нэмэгдүүлж байгаа юм.

Монгол улсын хувьд байгууллага үйл ажиллагаа явуулахад тэр дундаа уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хууль эрх зүйн зохицуулалт сул, засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагаас ирэх дарамт шахалт их байна. Мөн ашигт малтмалын тухай хуулинд маш их ойлгомжгүй зүйлс байдаг нь үйлажиллагаанд маш их сөргөөр нөлөөлж байна. Жишээ нь Уурхай байгууламжийн ажлыг 3 жилд багтаан хийх ёстойгоор хуульчилсан, гэтэл том төслүүдийн ашиглалтанд орох хугацаа харьцангуй мөн тухайн Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүлээн авснаас хойш тухайн ашигт малтмалын үнэ унаад ашигтай биш болвол хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байдаг. Мөн бүхийл үйл ажиллагаа бүхийл зүйл нь төрийн захиргааны албан хаагчдын хувийн үзэмж ашигсонирхлоор шийдэгддэг болсон байна.

“” ХХК нь монгол улсын Татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, НД-н тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Ус нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг хууль тогтоомжийн хүрээнд дээрх татвар хураамжуудыг улсын төсөвт төвлөрүүлж ажиллаж байна.

- Тусгай зөвшөөрлийн төлбөр

- Ус ашигласны төлбөр
- Үл хөдлөх хөрөнгийн татвар
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- Үнийн өсөлтийн албан татвар
- НДШ, ЭМДШ
- Газар ашигласны төлбөр
- Ус ашигласны төлбөр
- Хүн амын орлогын албан татвар

Дээрх татвар хураамжуудыг төлсөнөөр улсын төсөвт 2010 онд 323,78 саят өгрөгийг оруулж ажиллаж байна.

Орон нутгын төр, иргэний байгууллага, иргэдтэй харилцах харилцаа.

Уг уурхай нь байгуулагдсанаар тухайн орон нутагт багагүй хөрөнгө оруулалтыг хийгээд байгаа бөгөөд мөн уг уурхай нь 40 орчим ажиллагсадтай бөгөө дэдгээрийн 60 орчим хувийг орон нутгийн иргэдээс бүрдүүлж, тогтмол цалинтай ажлын байраар хангаад байна. Мөн орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжиж хэрэглээнийхээ дийлэнхийг орон нутгаас худалдаж авах малчид ард иргэдтэй хамтран ажиллаж байна. 2010 онд Сүхбаатар сумын ардиргэд малчидыг ундны усаар хангах үүднээс орон нутагт худаг гаргасан. Мөн уурхайгаас Чойбалсан хот хүртэл сайжруулсан шороон замаар холбосон бөгөөд үүгээр сумын иргэд Чойбалсан хотруу сайжруулсан шороон замаар зорчих таатай нөхцөл бүрдээд байна.

“” ХХК-н өрсөлдөөний таван хүчний шинжилгээ

Уул уурхан балбар нь маш их онцлогтой бөгөөд уг салбарт өрсөлдөөн зарим нөхцөлд их байдаг бөгөөд зарим тохиолдолд өрсөлдөөн огт байхгүй байх тохиолдолч бий.

Өрсөлдөөний үзүүлэлтүүд	Нөхцөл байдал	Өрсөлдөөний эрчим
Төмөрийн хүдэр олборлолтын салбарын өрсөлдөөний төлөв байдал		
Салбарын өрсөлдөгчдийн тоо	Харьцангуй цөөн	Салбарын өрсөлдөгчдийн хувьд өрсөлдөөн сул, харин ч хамтран
Салбараас гарахад тулгарах бэрхшээл	Маш их	
Бүтээгдэхүүн үйлчилгээний ялгаварлал	Ялгаварлал маш бага	
Салбарын өсөлт	Эрчимтэй өсөж байгаа	

Салбарын ач холбогдол	Дунд	ажиллах хандлагатай байна
Худалдан авагчийн нөлөөлөл /Төмөрийн хүдэр олборлолтын салбарт /		
Худалдан авах хэмжээ	Маш их	Худалдан авагчаас үзүүлэх нөлөөлөл маш их байгаа бөгөөд, худалдан авагч нь БНХАУ-н ганц үйлдвэр байдаг.
Чанарт үзүүлэх нөлөөлөл	Маш их	
Хэрэглэгчдийн мэдээлэл	Дутмаг	
Худалдан авагчийн ашиг	Их	
Худалдан авагчдын тоо	Нэг	
Бэлтгэн нийлүүлэгчдээс үзүүлэх нөлөөлөл		
Нийлүүлэгчдийн төвлөрөл	Бага	Бэлтгэн нийлүүлэгчээс үзүүлэх нөлөөл маш их байна.
Өөр нийлүүлэгчтэй хамтран ажиллахад гарах зардал	Маш их	
Шинээр нэвтрэгчидийн нөлөөлөл		
Үнийн өрсөлдөөн	Маш бага /бараг байхгүй/	Шинээр нэвтрэгчдийн аюул бага байна. Шинээр өрсөлдөгч нэвтрэх нь бага
Тухайн салбарт нэвтрэн орох босго	Босго маш өндөр	
Зардлын хувьд туйлын давуу талтай байх	Зардал бага байх нь ашигт маш их нөлөөлөл	
Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр хүнд чанар	Чанар сатай байх	
Хууль эрх зүйн зохицуулалт	Маш их	
Хөрөнгө оруулалт	Маш их	
Түгээлтийн сувагт нэвтрэх боломж	Их байвал өрсөлдөөн хүчтэй болно	
Эдийн засгийн үр ашиг	Их	
Үтээгдэхүүний ялгарал	Бараг байхгүй	
Орлуулах бүтээгдэхүүний нөлөөлөл		
Орлуулах бүтээгдэхүүн	Байхгүй /чанарын хувьд л өөр өөр байж болно/	Орлуулах бүтээгдэхүүний аюул бага

Хүснэгт 4. ХХК-н Өрсөлдөөний 5 хүчний шинжилгээний хүснэгт

Шинэ өрсөлдөгч нэвтрэх аюул.

Уг салбарт маш онцлог салбар бөгөөд шинэ өрсөлдөгч нэвтрэх аюул маш бага байдаг учир нь түгээлтийн сувагт нэвтрэх боломж маш бага, мөн хууль эрх зүйн зохицуулалт маш их байдаг. Мөн Уг салбарт орохын тулд хөрөнгө оруулалт маш их шаарддаг бөгөөд өөрийн гэсэн ордтой байх шаардлагатай байдаг. Шинэ өрсөлдөгч нэвтэрсэнч хоорондын өрсөлдөөн зэх зээлээ хуваах зэрэг нь маш бага учир нь бүх компаниуд нь бүтээгдэхүүнээ гадаадын зах зээлд гаргадаг бөгөөд гаргаж буй бүтээгдэхүүн нь тухайн худалдан авагчиддаа маш бага хэмжээ эзэлдэг байна.

### Орлуулах бүтээгдэхүүний аюул.

Орлуулах бүтээгдэхүүн бараг байхгүй бөгөөд бусад метал буюу хөнгөн цагаан ашиглах боломж байгаа хэдий ч түүнийг хэрэглэх нь ховор юм. Тийм ч учраас орлуулах бүтээгдэхүүний аюул маш бага байдаг.

### Худалдан авагчдын нөлөөлөх чадвар.

Манай улсын хувьд БНХАУ-д үйлдвэрлэсэн төмөрийн хүдрээ гаргадаг бөгөөд тухайн улсын нийт хэрэгцээний 0,5%-г л хангадаг. Худалдан авагчдын зүгээс үзүүлэх нөлөөлөл маш их байдаг. Учир нь компани нэг л худалдан авагчтай бөгөөд тухайн худалан авагчийн хэрэгцээний маш бага хувийг хангадаг учир ач холбогдол нь бага байдаг. Тийм учраас худалдан авагчийн зүгээс үнээ бууруулах зэрэг шаардлага шахалт зэрэг маш их нөлөөлөл гарч байдаг. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй Хятдын хөрөнгө оруулалттай компаниуд бүтээгдэхүүнээ үйлдвэрлэсэн өртгөөрөө өөрийн оронд гаргадаг учир манай улсын болон бусад улсын хөрөнгө оруулалттай компаниудад ихээхэн дарамт болж байдаг. Тэдгээр компаниуд нь ашгаа манай улсад оруулж ирэлгүйгээр шууд өөрийн оронд үлдээн татвараас зайлс хийх зэрэг алхмууд маш их байдаг.

### Нийлүүлэгчдийн нөлөөлөх чадвар.

Нийлүүлэгчийн зүгээс үзүүлэх нөлөөлөл маш их байдаг ба уул уурхайн компанийн хувьд гол түүхий эд нь сэлбэг хэрэгсэл, түлш шатхуун байдаг. Сэлбэг хэрэгсэлийн хувьд ихэнхийг нь БНХАУ-с авдаг бөгөөд нийлүүлэгчийн зүгээс үзүүлэх дарамт шахалт маш их байдаг. Жил бүр БНХАУ-н компаниуд өмнө жил үйлдвэрлэж байсан тоног төхөөрөмжөө шинэчилж, загвар дизайнаа өөрчилж байдаг учир сэлбэг хэрэгслийн татан авалт дээр маш их асуудалтай байдаг. Өөр бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран ажмжиллах боломж маг хомс байдаг.

Түлш шатах тослох материалын хувьд манай улсад энэ зах зээл нь өөрөө монополь зах зээл учир бэлтгэн нийлүүлэгчээс ихээхэн хамаардаг. Манай улсын компаниудын хувьд хуувилдаж үнээ өсгөх зэрэг маш олон дарамт шахалт их байдаг. Түлш шатах тослох материалын хувьд нийлүүлэгчээ солиход нэг их хүндрэлтэй бишч монополь зах зээл учир чанарын ялгаа бараг байдаггүй бүгд бараг адил үнийн саналтай байдаг. Мөн нийлүүлэгчээ солиход гарах зардал харицангуй их байдаг.

Салбарын өрсөлдөөний төлөв байдал.

Салбарын өрсөлдөөний төлөв байдал харьцангуй бага ба салбараас гарах зардал маш өндөр байдаг ба үүнд нөхөн сэргээлтийн зардал, байгал орчин хамгаалах зэрэг маш их зардлууд гардаг. Зах зээлийн хувьд урд хөрш болох хятад улс дэлхийн гангийн үйлдвэрлэлийн 60% орчмыг дангаараа үйлдвэрлэдэг ба эрэлтийн түвшин өсөж байна. Иймээс ч шинээр нэвтрэгчид эрчимтэй өсөж байгаа бөгөөд шинэ шинэ ордууд нээгдэж байна.

## “” ХХК-н дотоод орчны шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн үеийн сайн чанарын техник тоног төхөөрөмжтэй</li> <li>• Чадварлаг туршлагатай боловсон хүчин</li> <li>• Санхүүжилтийн эх үүсвэр сайн</li> <li>• Одоогийн тогтоогдоод байгаа нөөц 8 сая тонн</li> <li>• Төмрийн хүдэр олборлогч компаниудын дунд анхдагч учир бусдаас илүү туршлагатай</li> <li>• Магнетит хэмээх баяжигдах чанар маш их төмрийг олборлодог.</li> <li>• Тогтоогдоогүй таш их нөөцтэй</li> <li>• Хөрөнгө оруулагчдын анраахлыг ихээр татаж байгаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Техникийн эвдрэл гэмтлийг засахад сэлбэг хэрэгсэл дутагдалтай</li> <li>• Хүний нөөцийн оновчтой бодлого төлөвлөлт байхгүй</li> <li>• Шагнал урамшууллын систем дутагдалтай</li> <li>• Олборлож буй төмрийн хүдэр нь маш их цахиуртай</li> <li>• Цахилгааны шугамд холбогдоогүй</li> <li>• Техник тоног төхөөрөмж хуучирч муудсан</li> <li>•</li> </ul>

Хүснэгт 5. Дотоод орчны шинэжилгээ

## Хүснэгт 6. “” ХХК-н Үнэт зүйлс, Эрхэм зорилго, Зорилго,Зорилтууд

Байгууллагын нэр (хэмжээ)	ХХК
Бизнесийн талбар	Уул уурхай
Эрхэм зорилго	•Чадварлаг боловсон хүчин, шилдэг технологи бүхий орчин үеийн хариуцлагатай уул уурхайн компани байна.
Үнэт зүйлс	Чадварлаг Боловсон хүчин
	Шилдэг техник технологи

	Найдвартай санхүүгийн эх үүсвэр
	Харилцан ашигтай урт хугацааны хамтрагч компаниуд
	Байгаль орчинд халгүй үйл ажиллагаа
	Орон нутгийн хамтын ажиллагаа
Урт, дунд хугацааны бизнесийн зорилго, зорилт	1. Хамгийн сүүлийн үеийн Төмрийн хүдэрийг баяжуулах технологитой баяжуулах үйлдвэртэй болох
	2. Нөөцийг нэмэгдүүлэх хайгуулын ажил явуулах
	3. 1 жилд 100,000 тн баяжмал үйлдвэрлэдэг болох
	4. Хүний нөөцийн бодлого төлөвлөлт боловсруулах
	5. Ажилчдаа чадваржуулан мэргэжлийн боловсон хүчинбэлтгэх
Богино хугацааны зорилго, зорилт	Цахилгаан шугамтай болж эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй холбогдох
	Сард 12,500 тн баяжмал гаргах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр барьж байгуулах
	Хаягдалын дахин ашиглах усаар угаах боложтой жижиг оврийн шугам байрлуулах
	Уулын хэсгийн хүчин чадалыг баяжуулах үйлдвэрийн хүчин чадалтай уялдуулах нэмэгдүүлэх
	Өрмийн хэсгийн хүчин чадалыг гуулын хэсгийн хүчин чадалтай уялдуулан нэмэгдүүлэх
	Компанийн бүтэц зохион байгуулалтыг шинээр бий болгох

“” ХХК-д Cross - SWOT шинжилгээ хийж стратегийг тодорхойлох

“” ХХК-н гадаад болон дотоод орчны шинжилгээг бүрэн хийсний дараа санхүү, дотоод бизнесийн процесс, хүний нөөц сургалт хөгжил гэсэн 3 хүрээнд Cross- SWOT шинжилгээг хийж тус бүрээс урт, дунд болон богино хугацааны стратегиудын сонголтуудыг хийсэн.

Хүснэгт 7. Санхүүгийн орчны Cross - SWOT шинжилгээ

SWOT шинжилгээ	
<p>S-Давуу тал</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Найдвартай хөрөнгө оруулагчтай</li> <li>2. Үйл ажиллагаа тогтвортой</li> <li>3. Бүтээгдхүүнээ нийлүүлдэг найдвартай харилцагчидтай.</li> <li>4. Урьдчилгаа төлбөр авч байж бүтээгдэхүүнээ ачуулдаг.</li> </ol>	<p>W-Сул тал</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Мөнгөн хөрөнгийн хуримтлал үүсгэх боломж хязгаарлагдмал. Эрсдлээс хамгаалах сан байдаггүй.</li> <li>2. Шаардлагатай үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх болон бараа материалын хүрэлцэхүйц нөөцийг бүрдүүлэхэд бэлэн мөнгөний байнгын хомсдолтой байдаг.</li> </ol>
